



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ОЮУТАН, ТӨГСӨГЧИЙН ХЭЛТЭС

ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

(2018-2019 оны хичээлийн жилд төгсөгчдийн
мөшгих судалгаа)

УЛААНБААТАР 2020

Судалгааг зохион байгуулсан: Оюутан, төгсөгчийн хэлтэс /ОТХ/

Судалгааг гүйцэтгэсэн багийн гишүүд:

Багийн зөвлөх

М.Батбаатар, МУИС-ийн СНАТ-ийн дэд профессор

Мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн

Т.Лхагва, БССТ-ийн магистр

Л.Хулан, СНАТ-ийн магистрант

Мэдээлэл цуглуулсан судлаачид:

Ч.Амаржаргал, оюутан

М.Анхбаяр, оюутан

У.Буяндэлгэр, оюутан

Ч.Дэлгэрмаа, оюутан

Д.Мигар, оюутан

С.Оюунтуяа, оюутан

С.Содгэрэл, оюутан

Э.Сумъяа, оюутан

Б.Цэрэндолгор, оюутан

М.Цэрэнлхам, оюутан

Мэдээллийг тоон хэлбэрт шилжүүлсэн

Э.Сарангэрэл, Оюутан, төгсөгчийн хэлтсийн мэргэжилтэн

Т.Зулбадам, Оюутан, төгсөгчийн хэлтсийн мэргэжилтэн

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж,
МУИС-ийн 2-р байр, 2 давхарт, 216 тоот

Утас: 77307730-1561

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	4
ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	5
СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ.....	6
БҮЛЭГ НЭГ. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ.....	8
1.1. Судалгааны зорилго	8
1.2. Судалгааны арга зүй, аргачлал	9
1.3. Судалгааны түүвэрлэлт, дизайн	9
1.4. Судалгааны мэдээлэл цуглуулах, боловсруулах аргачлал	11
1.4.1. Судалгааны зохион байгуулалт	11
1.4.2. Судалгааны үндсэн ойлголт, тодорхойлолт.....	11
1.4.3. Мэдээлэл боловсруулсан аргачлал	12
БҮЛЭГ ХОЁР. ТӨГСӨГЧДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	13
2.1. Төгсөгчдийн нийгэм, хүн ам зүйн байдал	13
2.2. Төгсөгчдийн эзэмшсэн мэргэжлийн чиглэл, эрхэлж буй ажил.....	18
БҮЛЭГ ГУРАВ. ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ	23
3.1. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, цалин орлого	26
3.2. Төгсөгчдийн ажилгүйдэл, түүний шалтгаан	32
БҮЛЭГ ДӨРӨВ. ИХ СУРГУУЛИЙН ХӨТӨЛБӨР БА ҮЙЛЧИЛГЭЭНД ӨГСӨН ТӨГСӨГЧДИЙН ҮНЭЛГЭЭ	36
4.1. МУИС-ийн хөтөлбөрийн давуу болон сул талыг үнэлсэн байдал	36
4.2. МУИС-ийн сургалтын хөтөлбөрийн давуу ба сул тал, анхаарах зүйлс ...	45
4.3. Төгсөгчдийн холбоо ба мэдээллийн санг үүсгэх талаар оролцогчдын санал бодол.....	47
4.4. Их сургуулиас авсан үйлчилгээний талаарх үнэлгээ.....	49
БҮЛЭГ ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ	51
ХАВСРАЛТУУД.....	54

ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Оюутан, төгсөгчийн хэлтсээс явуулж буй “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа” нь судалгааны өвөрмөц аргачлал болох мөшгих(follow up) хэлбэрээр жил бүр зохион байгуулагддаг, түүврийн төлөөлөх чадвар сайтай хийгддэг давуу талтай.

Энэ удаагийн судалгаанд 2018-2019 оны хичээлийн жилд төгсөгчдийн 40-өөс багагүй хувийг хамруулж, тэдгээрийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, хувь хэмжээг тодорхойлсон бөгөөд Социологи, нийгмийн ажлын тэнхимтэй хамтран, мэргэжлийн зөвлөх багш, судалгааны мэргэжлийн магистрант, оюутнуудыг ажиллуулснаараа онцлог юм.

Тус судалгааны үндсэн зорилго нь төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, эрхэлж буй ажлын төрөл хэлбэр, ажилд ороход нөлөөлсөн хүчин зүйлс, ажил эрхлэхгүй байгаа бол үндсэн шалтгааныг тодорхойлж, их сургуулиас оюутанд үзүүлж буй үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж гаргахад чиглэсэн.

Төгсөгчдийн судалгааны мэдээллийг цуглуулахдаа компьютерт суурилсан телефон сурвалжилга/CATI/-ын аргыг ашигласан бөгөөд мэдээллийг SPSS 23.0 программ дээр боловсруулсан юм.

Өнөөгийн хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлтийн үйл явцтай уялдуулан төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлыг гаргах, ажилгүйдлийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, их сургуулиас бэлтгэгдэж буй мэргэжилтний ур чадвар хөдөлмөрийн зах зээлд нийцэж буй эсэх, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтэд тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, суралцах хугацааны хөтөлбөрийн давуу болон сул талыг үнэлүүлэх замаар сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд уг судалгааны үр дүн, ач холбогдол оршино.

Судалгааны үр дүн, тайлантай танилцаж, өөрсдийн үйл ажиллагаанд тусгахын зэрэгцээ аргачлал болон дүн шинжилгээтэй холбоотой санал хүсэлтээ ОТХ (МУИС-ийн 2-р байр, 216 тоот) болон цахим хаягаар илгээж хамтран ажиллахыг хүсье.

ОЮУТАН, ТӨГСӨГЧИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



М.ЭРДЭНЭЧИМЭГ

ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт-1.1 2018-2019 оны хичээлийн жилд МУИС-ийг төгсөгчдийн тоо	9
Хүснэгт-1.2 Түүврийн тоо хэмжээ	10
Хүснэгт-2.1 Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн тоо.....	13
Хүснэгт-2.2 Төгсөгчдийн сурлагын дүнгийн дундаж/сургуулиар/	14
Хүснэгт-2.3 Төгсөгчдийн ажиллаж, амьдарч буй газар	15
Хүснэгт-2.4 Төгсөгчдийн сарын дундаж цалин орлогын тооцоолол.....	15
Хүснэгт-2.5 Төгсөгчдийн орлогын түвшин	16
Хүснэгт-2.6 Төгсөгчдийн орлогын дундаж үзүүлэлт, сургууль тус бүрээр	17
Хүснэгт-2.7 Төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал /хүйсээр/.....	20
Хүснэгт-2.8 Төгссөн сургууль ба ажил эрхлэлт	22
Хүснэгт-3.1 Төгсөгчдийн судалгааны мэдээлэл.....	23
Хүснэгт-3.2 Сургууль төгсөөд ажилд орсон хугацаа.....	23
Хүснэгт-3.3 Ажилд ороход нөлөөлсөн хүчин зүйлс	24
Хүснэгт-3.4 Ажилд ороход нөлөөлсөн хүчин зүйлс /хүйсийн байдлаар/	25
Хүснэгт-3.5 Ажил эрхлэлтийн байдал ба орлогын дундаж	26
Хүснэгт-3.6 Үл хамаарах Т шинжүүр, хүйсийн ялгаа ба орлогын дундаж үзүүлэлт	27
Хүснэгт-3.7 Корреляцийн шинжилгээний үр дүн.....	27
Хүснэгт-3.8 Мэргэжлийн чиглэл: голч оноо, ажил эрхлэлт, сарын дундаж орлого.....	28
Хүснэгт-3.9 Ажил хайх явцад гардаг хүндрэл, бэрхшээл	32
Хүснэгт-3.10 МУИС-ийг төгсөгчдийн хувьд ажил эрхлэхгүй байгаа шалтгаан	33
Хүснэгт-3.11 Мэргэжлийн ажлаа хийж байгаа эсэх?, төгссөн сургуулиар	34
Хүснэгт 4.1 Орон нутаг дахь салбар сургуулийг төгсөгчдийн үнэлгээ	45
Хүснэгт 4.2 Төгсөгчдийн холбоо байгуулахыг дэмжиж байна уу?.....	48
Хүснэгт 4.3 Мэдээллийн сан үүсгэхийг дэмжиж байна уу?	48
Хүснэгт 4.4 Хэмжилтийн үндэслэлтэй байдал.....	49
Хүснэгт 4.5 МУИС-аас төгсөгчдөд үзүүлсэн үйлчилгээ.....	49
График-2.1 Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн хүйсийн байдал.....	14
График-2.2 Төгсөгчдийн сарын дундаж мөнгөн орлогын харьцуулалт.....	16
График-2.3 Төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал.....	18
График-2.4 Төгсөгчдийн ажил эрхлэлтийн хэмжээ /оноор/	19
График-2.5 Төгсөгчдийн эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж буй хувь	20
График-2.6 Төгсөгчдийн эрхэлж буй ажлын төрөл, хэлбэр	21

СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

Төгсөгчдийн судалгааны үндсэн зорилго нь төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, эрхэлж буй ажлын төрөл хэлбэр, ажилд ороход нөлөөлсөн хүчин зүйлс, ажил эрхлэхгүй байгаа бол үндсэн шалтгааныг тодорхойлж, их сургуулиас оюутанд үзүүлж буй үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж гаргахад чиглэдэг.

Нийт өвөл ба хаврын төгсөлтийн харьцааг авч үзэхэд МУИС-ийн нийт 7 бүрэлдэхүүн сургуульд суралцаж, 22.5 хувь нь өвөл, 77.5 хувь нь хаврын улиралд тус тус төгссөн байна. Энэ удаагийн судалгаанд 2018-2019 оны хичээлийн жилд төгсөгчдийн 40-өөс багагүй хувь буюу 1031 төгсөгчдийг хамруулж, тэдгээрийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, хувь хэмжээг тодорхойлсон юм.

Хүйсийн хувьд авч үзэхэд судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 67 хувь нь эмэгтэй, 33 хувь нь эрэгтэй оюутнууд байлаа.

Судалгааны үр дүнгээс үзэхэд нийт төгсөгчдийн 75.7 хувь нь ажил эрхэлдэг бол, 24.3 хувь нь ямар нэг ажил эрхлээгүй гэсэн хариултыг өгсөн. 2015-2017 оны төгсөгчдийн түүвэр судалгаанаас үзэхэд 2015 онд төгсөгчдийн 72.8 хувь, 2016 онд төгсөгчдийн 73.4 хувь, 2017 онд төгсөгчдийн 73.0 хувь нь хөдөлмөр эрхэлж байсан дүн мэдээтэй харьцуулахад төгсөгчдийн ажил эрхлэлт өмнөх онуудаас өссөн байна.

2018 онд МУИС-ийг төгсөгчдийн хувьд 63.9 хувь нь эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж байгаа бөгөөд улсын дундаж үзүүлэлтээс дунджаас 5.7 хувиар доогуур байна. Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн цөөнгүй хэсэг хувиараа аж ахуй эрхэлж буй хүмүүс байгаа нь дээрх үзүүлэлтэд тодорхой хэмжээгээр нөлөөлжээ.

Төгсөгчдийн сарын дундаж орлогыг тооцож үзэхэд 1065.1 мянган төгрөг байгаа бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүйсийн хувьд харьцуулж үзэхэд бага зэрэг ялгаа харагдаж байна. Тухайлбал эмэгтэйчүүдийн хувьд дунджаар 968.5 мянган төгрөгийг дундаж орлогыг сард олдог бол эрэгтэйчүүд сард дунджаар 1255.4 мянган төгрөгийн орлого олдог буюу

286.9 мянган төгрөгөөр илүү орлоготой байв.

МУИС-ийн 2018-2019 оны хичээлийн жилд төгсөгчдөөс 20.9 хувь нь суралцах үедээ болон төгссөн даруйдаа ажил хөдөлмөр эрхэлсэн байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд төгсөгчдийн 17.0% нь 4-7 сарын хугацаанд, 9.6% нь 8-12 сарын хугацаанд ажил хөдөлмөр эрхэлсэн бол, нийт төгсөгчдийн 6.9% нь нэг жил буюу түүнээс дээш хугацаанд хүлээж байж ажил хөдөлмөр эрхэлсэн байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд ажил эрхлэлт хамгийн өндөртэй гурван сургуульд ОУХНУС-88.9%, Бизнесийн сургууль-86.2%, Хууль зүйн сургууль-85.6% багтаж байна. Эдгээр сургуулийг төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь улсын дунджаас(75.2%) 10.4-13.7 хувиар өндөр байгаа юм.

ХШУИС болон Завхан, Эрдэнэт сургуулиудын төгсөгчдийн 72-76 хувь нь ажил эрхэлж байгаа нь дундаж үзүүлэлт болно. Харин ШУС-ийг төгсөгчдийн хувьд ажил эрхлэлт 67.3 хувьтай байгаа нь хамгийн бага үзүүлэлт бөгөөд улсын дунджаас 7.9 хувиар доогуур байна. Төгсөгчдийн хувьд ажилд ороход нөлөөлсөн хүчин зүйлсийг дараах байдлаар нэрлэсэн. Тухайлбал, ажилд ороход хувийн зан чанар-23.5%, төгссөн сургууль-22.7%, Ерөнхий ур чадвар-16.8% тус тус ихээхэн нөлөөлдөг эхний гурван хүчин зүйл болохыг төгсөгчид онцолжээ.

Хүйсийн хувьд харьцуулан авч үзэхэд ажилд ороход эрэгтэй төгсөгчдийн хувьд **1) хувийн зан чанар-45.5%, 2)төгссөн сургууль-39.1%, 3)ерөнхий ур чадвар-37.5%**, ихээхэн нөлөөлдөг бол, эмэгтэй төгсөгчдийн хувьд **1)төгссөн сургууль-43.1%, 2)хувийн зан чанар- 42.0%, 3)ерөнхий ур чадвар-27.2%** тус тус нөлөөлсөн байна.

Ерөнхийдөө, МУИС-ийн сургалтын хөтөлбөрийн сул талаас илүүтэй давуу талыг төгсөгчид олонтаа дурдсан байна. Нөгөө талаар сургалтын хөтөлбөрт шууд хамаатай сул талуудыг төгсөгчид харилцан адилгүй илэрхийлсэн ба тухайлбал, Бизнесийн сургуулийг төгсөгчид багш, ажиллагсадтай холбоотой саналууд, багшийн ур чадвар, туршлагыг нэмэгдүүлэх, ажилчдын харилцааг сайжруулах талаар дурдсан бол ШУС, ХЗС, ОУХНУС, ХШУИС-ийг төгсөгчид хичээлийн хөтөлбөрийг хөгжүүлэх, Sisi системийг хөгжүүлэх шаардлагатай байгаа талаар зонхилон хариулт өгсөн байна.

МУИС-ийг төгсөгчдийн 90 гаруй хувь нь Төгсөгчдийн холбоог тогтвортой ажиллахыг дэмжсэн хариулт өгсөн бол төгсөгчдийн мэдээллийн сан байгуулахыг төгсөгчдийн 60 гаруй хувь нь дэмжсэн хариулт өгсөн байна. МУИС-аас төгсөгчдөд үзүүлсэн үйлчилгээнд өгсөн үнэлгээний дундаж үзүүлэлтийг тооцож үзэхэд Цахим үйлчилгээ-3.62, Оюутны тэтгэлэг, санхүүгийн дэмжлэгийн үйлчилгээ-3.46, Оюутны байрны үйлчилгээ-3.45 харьцангуй өндөр үнэлгээтэй байгаа бол Эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад үзүүлэх үйлчилгээг 2.95 буюу дунджаас доогуур үнэлжээ.

БҮЛЭГ НЭГ. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

1.1. Судалгааны зорилго

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын 1.3.6-д “...ажилгүйдлийн түвшин хөдөлмөрийн насны залуучуудын дунд ихсэж байгаа тул их дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөгчдөд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна” хэмээн тусгасан. Иймд Монгол Улсын их сургууль нэг талаас дээд боловсрол олгож буй тэргүүлэх институт, эрдэм шинжилгээ, сургалт, үйлдвэрлэлийн байгууллага болохын хувиар, нөгөө талаас хөдөлмөрийн зах зээлд мэргэжилтэн бэлтгэж буй томоохон нийлүүлэгч болохын хувьд төгсөгчдийн судалгааг тогтмол хийх шаардлагатай.

Өнөөгийн хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлтийн үйл явцтай уялдуулан төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал, онцлогийг судлах замаар ажилгүйдлийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, их сургуулиас бэлтгэгдэж буй мэргэжилтний ур чадвар хөдөлмөрийн зах зээлд нийцэж буй эсэх, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтэд тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, суралцах хугацааны хөтөлбөрийн давуу болон сул талыг үнэлүүлж, улмаар их сургуулийн зүгээс үзүүлж буй үйлчилгээ, сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх явдал нэн чухал билээ.

Энэхүү судалгаа нь МУИС-ийг 2018-2019 оны хичээлийн жилд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн төлөв байдалд дүн шинжилгээ хийж, хөдөлмөр эрхлэлт ба ажилгүйдлийн шалтгаан нөхцөлийг тодорхойлоход чиглэсэн юм.

МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулийг төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, сургалтын хөтөлбөрийн давуу болон сул талыг үнэлсэн үнэлгээнд тулгуурлан, тэнхим, нэгжээс салбар сургуулийн удирдлагын түвшин баримтлах чиглэл арга хэмжээнд хэрэгцээ бүхий дүгнэлт, зөвлөмж боловсруулан гаргах нь тухайн судалгааны үндсэн зорилго юм.

Судалгаагаар дэвшүүлсэн зорилгод хүрэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлж, шийдвэрлэсэн болно. Үүнд:

- § Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, түвшин, ажлын байрны олдоц, хүрэлцээг тодорхойлох
- § Төгсөгчдийн ажил хөдөлмөр эрхлэхэд тулгамдаж буй асуудал, бэрхшээл
- § Сургууль төгсөөд ажилд орсон хугацаа ба төгсөгчдийн салбар ба орлогын дундаж үзүүлэлтийн харьцааг тодорхойлох
- § Суралцах хугацааны хөтөлбөрийн сул ба давуу талууд, сайжруулах саналууд
- § Сургуулийн зүгээс үзүүлсэн үйлчилгээний талаарх үнэлгээ ба чанарыг сайжруулах талаарх үнэлгээ

§ Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт ба сургалтын хөтөлбөрийн үр дүнг сайжруулах чиглэлээр тайлан, санал дүгнэлт боловсруулах

1.2. Судалгааны арга зүй, аргачлал

Энэхүү судалгаанд тоон ба чанарын арга зүйг ашигласан ба хэлбэрийн хувьд мөшгих(follow up) судалгааны аргачлалд тулгуурласан болно.

Тус судалгаанд тоон ба чанарын судалгааны аргыг хослуулан ашигласан. Судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн шинжилгээний арга болон телефон сурвалжилгын аргыг хэрэглэсэн. Судалгааны тоон мэдээллийг SPSS 23.0 программ ашиглан боловсруулсан ба чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ, шинэ тэмдгээр кодлол хийж, ангилах, хэв маягчлах аргуудыг ашигласан.

1.3. Судалгааны түүвэрлэлт, дизайн

МУИС-ийг 2018-2019 оны хичээлийн жилд нийт 2512 оюутан 100 гаруй хөтөлбөрөөр суралцаж төгссөн юм. Нийт өвөл ба хаврын төгсөлтийн харьцааг авч үзэхэд МУИС-ийн нийт 7 бүрэлдэхүүн сургуульд суралцаж, 22.5 хувь нь өвөл, 77.5 хувь нь хаврын улиралд тус тус төгссөн байна.

Хүснэгт-1.1 2018-2019 оны хичээлийн жилд МУИС-ийг төгсөгчдийн тоо

МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль	Нийт төгссөн оюутны тоо		Өвлийн төгсөлт		Хаврын төгсөлт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Шинжлэх ухааны сургууль	982	39.1%	219	22.3	763	77.7
Бизнесийн сургууль	553	22.0%	89	16.1	464	83.9
Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль	118	4.7%	23	19.5	95	80.5
Хууль зүйн сургууль	264	10.5%	78	29.5	186	70.5
Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль	357	14.2%	95	26.6	262	73.4
Орхон салбар сургууль	159	6.3%	53	33.3	106	66.7
Завхан салбар сургууль	79	3.1%	9	11.4	70	88.6
НИЙТ	2512	100%	566	22.5%	1946	77.5%

Эх сурвалж: 2018 онд МУИС-ийг төгсөгчдийн статистик мэдээллээс түүвэрлэсэн.

Тус мэдээлэлд тулгуурлан нийт төгссөн оюутнуудын 40-өөс багагүй хувь буюу 1000 гаруй төгсөгчийг судалгаанд хамруулах зорилт тавьсан.

Түүврийн бүтэц, тоо хэмжээ

Тухайн түүвэрлэлтээр нийтдээ **1025**(өвлийн төгсөлт-228, хаврын төгсөлт-796) төгсөгч оюутан судалгаанд хамрагдах бөгөөд төгссөн жилийн оюутны тоо хэмжээнд тулгуурлан(өвлийн төгсөлт 22.5%, хаврын төгсөлт 77.5%) харгалзан сургууль тус бүрээс харгалзан оюутнуудыг хамруулахаар төлөвлөсөн болно.

Хүснэгт-1.2 Түүврийн тоо хэмжээ

МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль	Төлөвлөсөн түүвэрлэлт	Бодит түүвэрлэлт
Шинжлэх ухааны сургууль	405	444
Бизнесийн сургууль	222	246
Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль	49	36
Хууль зүйн сургууль	107	111
Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль	144	131
Орхон салбар сургууль	65	34
Завхан салбар сургууль	33	29
НИЙТ	1025	1031

Түүвэрлэлт хийсэн аргачлал

Судалгаанд хамрагдах оюутнуудыг сонгохдоо төгсөгчдийн нэрсийн жагсаалтад тулгуурласан ба системчилсэн санамсаргүй түүвэрлэлтийг ашигласан. Системчилсэн санамсаргүй түүвэрлэлтийг дараах байдлаар хийнэ. Үүнд: N / n

И- Эх олонлогийн хэмжээ

n-Түүвэр олонлогийн хэмжээ

Жишээ нь, Шинжлэх ухааны сургуулийн хувьд N=1025, n=405 байх бөгөөд алхамыг тооцох томьёо ёсоор (N/n) түүврийн алхам нь ойролцоогоор 3 байна. Иймд түүвэрлэлтийг хийхдээ нэрсийн жагсаалтаас эхний 3 төгсөгчийн нэрсээс аль нэгийг санамсаргүйгээр сонгон, цааш гурав алхамтайгаар түүвэрлэлтийг хийх юм. Тухайлбал судлаач нэрсийн жагсаалтаас санамсаргүй байдлаар 2 дахь төгсөгчийг сонгосон бол 5, 8, 11, 14, 17, 20, 23 дахь оюутныг тус тус цааш түүвэрлэн жагсаалтаас 405 оюутныг сонгон судлах юм.

Гэвч судалгаа хийх явцад түүврийн алхмын дагуу сонгогдсон оюутнуудын утас өөрчлөгдсөн, холбогдох боломжгүй, үйлчилгээний эрх хаагдсан зэрэг шалтгааны улмаас төгсөгч нэг бүртэй холбогдон, нэлэнхүй хэлбэрээр судалгааг авсан болно. Ингэснээр нийт судалгаанд 1031 төгсөгчийг хамруулж, түүврийн төлөөлөх чадварыг хангасан болно.

1.4. Судалгааны мэдээлэл цуглуулах, боловсруулах аргачлал

Судалгааны мэдээлэл цуглуулахад баримт бичгийн судалгаа болон телефон сурвалжилгын аргыг ашиглав. Статистик тоон мэдээлэл, өмнө нь хийгдсэн судалгааны тайлан, хоёрдогч эх сурвалжуудыг судлахад баримт бичгийн судалгааны аргыг хэрэглэсэн ба төгсөгч оюутнуудаас хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээллийг цуглуулахдаа телефон сурвалжилгын аргыг ашигласан болно. МУИС-ийг төгссөн оюутнууд Монгол орны өнцөг булан бүрт ажил хөдөлмөр эрхэлж буй тул телефон сурвалжилгын аргыг ашиглаж мэдээлэл цуглуулах нь мэдээллийг нэгж цаг хугацаанд цуглуулах болон цаг хугацаа, хөрөнгө санхүү хэмнэх давуу талтай байлаа. Нөгөө талаар холбоо барих, харилцах утас солигдож өөрчлөгдсөн, холбогдохгүй, үйлчилгээний эрх хаагдсан, татгалзсан зэрэг шалтгаанаар зарим төгсөгчдөөс мэдээлэл аваагүй, мөн зөвхөн утсаар холбогдсон хүмүүсээс мэдээлэл авах явдлаар хязгаарлагдсан нь тухайн судалгааны сул тал байж болох ч, төгсөгч нэг бүртэй холбогдож судалгаа авахыг эрмэлзсэн.

1.4.1. Судалгааны зохион байгуулалт

Судалгааг ОТХ-ийн мэргэжилтнүүд зохион байгуулж явуулсан бөгөөд судалгааны зөвлөх, шинжээчид, судалгааны мэдээлэл цуглуулах туслах судлаачдын баг ажилласан нь тухайн судалгааг илүү үр дүнтэй болоход нөлөөлсөн.

Судалгааны удирдамж, үндсэн асуултыг хэлтсийн мэргэжилтэн, зөвлөх багш хамтран боловсруулсан(Хавсралт хэсгээс үзнэ үү!) бөгөөд судалгааны мэдээлэл цуглуулах судлаачдад зориулж мэдээлэл сургалт зохион байгуулсны үндсэн дээр телефон сурвалжилгын арга ашиглан, төгсөгч бүртэй нэгбүрчлэн холбогдож мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг явуулсан юм. Мэдээлэл цуглуулахад анхаарах ёс зүйн болон үйл ажиллагааны удирдамжийг судлаачид мэдээлэл цуглуулахын өмнө уншиж танилцсан бөгөөд мэдээллийн найдвартай байдлыг хангахад эерэгээр нөлөөлсөн. Мэдээлэл цуглуулсан болон дүн шинжилгээ хийсэн судлаачид зөвлөхтэй хамтран судалгааны тайланг хамтран бичихэд оролцсон.

4.1.2. Судалгааны үндсэн ойлголт, тодорхойлолт

Судалгаанд ашигласан ойлголт, нэр томъёог “Үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт”-ын хүрээнд авч үзсэн ба тайланд дурдагдсан нэр томъёог дараах үндсэн тодорхойлолтын хүрээнд авч үзэж, хэрэглэсэн.

Мөшигх судалгаа: Аливаа үзэгдэл үйл явцын дараах нөхцөлийг тодорхойлох судалгаа юм. Эрүүл мэндийн судалгаанд цөөнгүй дурдагддаг. Өвчтөнд эмчилгээ хийсний дараа үр нөлөөг нь тодорхойлоход ашиглагдаж буй судалгааг мөшигх(follow-up) судалгаа хэмээн дурджээ. Хожим нь хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, ялангуяа төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд ашиглах болсон судалгааны өвөрмөц арга юм.

Сарын дундаж цалин, орлого: Цалин хөлстэй ажилтны хувьд цалингаар, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил олгогчийн хувьд орлогоор илэрхийлэгдэнэ. Нийт төгсөгчдийн сарын цалин, орлогын арифметик дунджаар тооцсон утгыг илэрхийлнэ.

Төгсөгч: 2018-2019 оны хичээлийн жилд их сургуулийн багц цагийг ханган, төгсөлтийн шалгалтад тэнцэж, бакалаврын диплом, авсан төгсөгч иргэнийг хэлнэ.

Ажилгүй иргэн: Тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хэлнэ.

Хөдөлмөр эрхлэлтийн хувь: Нийт төгсөгчдөд хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн эзлэх хувийн жингээр илэрхийлэгдэнэ.

$$\text{Хөдөлмөр эрхлэлтийн түвшин(\%)} = \frac{\text{Хөдөлмөр эрхэлж буй төгсөгч}}{\text{Нийт төгсөгч}} \times 100$$

1.4.3. Мэдээлэл боловсруулсан аргачлал

Судлаачид цуглуулсан мэдээлэлд шинжилгээ хийхдээ анхдагч болон харьцуулсан тоололтыг SPSS 23.0 программ ашиглан хийсэн. Мөн дүгнэх буюу тайлбарлах статистик шинжилгээг зөвлөхтэй хамтран магистрант оюутнууд гүйцэтгэсэн болно. Чанарын мэдээллийн шинжилгээний хүрээнд мэдээллийг кодлох, бүлэглэх, хэв маягчлах аргуудыг ашигласны зэрэгцээ тоон мэдээллийн хувь, хэмжээг тайлбарлах, шалтгаан, үр дагаврыг тодорхойлох, логик шинжилгээ тус тус хийсэн.

БҮЛЭГ ХОЁР. ТӨГСӨГЧДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2.1 Төгсөгчдийн нийгэм, хүн ам зүйн байдал

Шинжлэх ухааны сургуулийг 2018 онд нийт 982 оюутан төгссөн бөгөөд өвөл 219, хавар 763 оюутан төгссөн байна. ШУС-ийг төгсөгчдийн хувь хэмжээг авч үзэхэд МУИС-ийн нийт төгсөгчдийн 39.1 хувийг эзэлж байна. Бизнесийн сургуулийг 2018 оны өвөл 89, хавар 464 нийт 553 оюутан төгссөн бөгөөд МУИС-ийг төгссөн нийт оюутнуудын 22 хувийг эзэлж байна. 2018 оны байдлаар ХШУИС-ийг 357 оюутан төгссөн бөгөөд нийт төгсөгчдийн 14.2 хувь болж байна. Хууль зүйн сургуулийг 2018 онд 264 оюутан суралцаж төгссөн бөгөөд 78 оюутан өвөл, 186 оюутан хавар төгссөн юм. Нийт төгсөгчдийн 10.5 хувийг эзэлж байна. Орхон салбар сургуулийг нийт 159 оюутан төгссөн ба МУИС-ийг төгсөгчдийн 6.3 хувийг эзэлж байгаа болно. Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийг өвөл 23, хавар 95 оюутан тус тус төгссөн бөгөөд МУИС-ийг төгсөгчдийн 4.7 хувь болж байна. Завхан салбар сургуулийг 2018 онд 79 оюутан төгссөн ба нийт төгсөгчдийн хамгийн бага хувийг(3.1 хувь) эзэлж байна.

Судалгаанд 2018-2019 оны хичээлийн жилд бакалаврын боловсрол эзэмшиж төгссөн 2512 төгсөгчдөөс 1031 оюутнуудыг төлөөлөл болгон судалсан. Тухайн түүвэрлэлт нь нийт эх олонлогийн 41 хувь болж байна. Судалгаанд хамрагдсан сургуулийн төгсөгчдийн тоонд үндэслэн түүврийн тоо хэмжээг хувь тэнцүүлэн сонгохыг чухалчилсан бөгөөд Шинжлэх ухааны сургуулиас (444) 43.0%, Бизнесийн сургуулиас (246) 23.9%, ХШУИС-иас (131)

12.7%, ХЗС-иас (111) 10.8%, ОУХНУС-иас (36) 3.5%, Орхон салбар сургуулиас (34) 3.3%, Завхан сургуулиас (29) 2.8% оюутан тус тус хамрагдсан байна.

Хүснэгт-2.1 Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн тоо

		Тоо	Хувь
Шинжлэх ухааны сургууль	Байгалийн ухааны салбар	192	18.6
	Нийгмийн ухааны салбар	88	8.5
	Хүмүүнлэгийн ухааны салбар	164	15.9
Бизнесийн сургууль		246	23.9
Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль		131	12.7
Хууль зүйн сургууль		111	10.8
Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль		36	3.5
Орхон салбар сургууль		34	3.3
Завхан салбар сургууль		29	2.8
Нийт		1031	100.0

Тус судалгааны түүвэрлэлтийг хийхдээ өвөл ба хавар төгссөн оюутнуудыг мөн жигд хамруулахаар төлөвлөсөн бөгөөд төгсөгчдийн нэрсийн жагсаалтад тулгуурлан сонгохдоо системчилсэн санамсаргүй түүвэрлэлтийг ашигласан юм.

Хүйсийн хувьд судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 67 хувь нь эмэгтэй, 33 хувь нь эрэгтэй оюутнууд байлаа.



График-2.1 Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн хүйсийн байдал

Судалгааны хүрээнд ажил эрхлэлтийн онцлог, орлогын ялгаатай байдал, сурлагын голч, ажилгүй байгаа шалтгаан, сургуулийн үйлчилгээний талаарх үнэлгээ зэргийг хүйсийн онцлогтой харьцуулан, дүн шинжилгээ хийсэн болно.

Төгсөгч оюутнуудын хувьд харьцуулах шаардлагатай нэг үзүүлэлт бол тухайн суралцаж буй хугацааны амжилт буюу сурлагын голч дүн болно. Голч дүн буюу сурлагын амжилт нь оюутны цаашдын амьдралын гараа болсон хөдөлмөр эрхлэлтэд хэрхэн нөлөөлж буйг шинжлэх болно. Судалгаанд хамрагдсан төгсөгч оюутнуудын сурлагын дүнгийн голчийг сургууль тус бүрээр харьцуулахад дараах онцлог харагдаж байна. Үүнд:

Хүснэгт-2.2 Төгсөгчдийн сурлагын дүнгийн дундаж/сургуулиар/

Сургууль	N	Доод	Дээд	Дундаж
ОУХНУС	36	2.40	3.80	3.2722
Нийгмийн ухааны сургууль	262	2.00	3.90	2.9989
ХЗС	111	2.20	3.70	2.9973
Хүмүүнлэгийн ухааны сургууль	311	1.80	3.80	2.9543
Бизнесийн сургууль	553	1.80	3.90	2.8459
Байгалийн ухааны сургууль	408	1.80	3.80	2.7819
Завхан салбар сургууль	29	1.90	3.50	2.7276
ХШУИС	131	1.80	3.70	2.7122
Орхон салбар сургууль	159	1.60	4.00	2.6742

2018-2019 оны хичээлийн жилд төгссөн оюутнуудын сурлагын голч дүнг авч үзэхэд ОУХНУС, Нийгмийн Ухааны сургууль болон ХЗС-ийн төгсөгчдийн дундаж оноо хамгийн өндөр 2.99-3.27 байна. Харин Хүмүүнлэгийн ухааны сургууль, Бизнесийн сургууль болон Байгалийн ухааны сургууль төгсөгчдийн голч оноо дундаж хэмжээтэй буюу 2.78-2.95 байна. Хэрэглээний шинжлэх ухааны сургууль болон орон нутгийн салбар сургуулийг төгсөгчдийн дундаж оноо харьцангуй бага 2.67-2.72 байгаа юм.

Төгсөгчдийн ажиллаж, амьдарч буй байршил

Төгсөгчдийн ажиллаж амьдарч буй байршил, үндсэн захиргааг авч үзэхэд 63.2 хувь нь нийслэл хотод ажиллаж, амьдарч байгаа бол, 8 хувь нь аймгийн төвд, 3.5 хувь нь суманд, хувь нь бусад газарт ажиллаж байгаа гэсэн хариулт өгсөн байна.

Хүснэгт-2.3 Төгсөгчдийн ажиллаж, амьдарч буй газар

	Тоо	Хувь	Бодит хувь	Хуримтлагдсан хувь
Нийслэлд	652	63.2	63.2	63.2
Аймагт	82	8.0	8.0	70.2
Суманд	36	3.5	3.5	73.7
Хариулаагүй	239	23.2	23.2	96.9
Бусад	22	2.1	2.1	100.0
Нийт	1031	100.0	100.0	

Ажлын байр ихэвчлэн нийслэл хотод байгаа нь төгсөгчдийн оршин суугаа газраа сонгоход нөлөөлөөд зогсохгүй, төвлөрөл шилжих хөдөлгөөний татах хүчин зүйлийн нэг болжээ. Төгсөгчдийн сарын дундаж орлогыг тооцож үзэхэд 1065.1 мянган төгрөг байгаа бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүйсийн хувьд харьцуулж үзэхэд бага зэрэг ялгаа харагдаж байна. Тухайлбал эмэгтэйчүүдийн хувьд дунджаар 968.5 мянган төгрөгийг дундаж орлогыг сард олдог бол эрэгтэйчүүд сард дунджаар 1255.4 мянган төгрөгийн орлого олдог буюу 286.9 мянган төгрөгөөр илүү орлоготой байна.

Хүснэгт-2.4 Төгсөгчдийн сарын дундаж цалин орлогын тооцоолол

Хүйсийн байдал	N	Доод	Дундаж	Дээд	Хазайлт
Эрэгтэй	211	100000	1255360.19	10000000	1305281.379
Эмэгтэй	415	170000	968479.52	10000000	760152.279
Нийт	626	100000	1065175.72	10000000	986731.119

Энд төгсөгчдийн сард олж буй цалин орлогын хэмжээг 250 мянган төгрөгийн алхамтайгаар зургаан үндсэн бүлэгт хувааж, тархалтыг тооцов. Тухайн бүлгээс хамгийн их буюу 39.6 хувь нь 750-иас нэг сая хүртэл төгрөгийн орлоготой байна. Харин 501-750 мянга хүртэлх төгрөгийн орлоготой бүлэг 27.5 хувийг эзэлж байгаа бол 1-1.5 сая хүртэлх төгрөгийн орлоготой бүлэг 18.7 хувийг эзэлж байв. Орлогын хувьд 1.5 сая төгрөгөөс дээш орлоготой хэсэг 6.9 хувийг эзэлж байгаа бол эсрэгээр 250 мянга хүртэлх, хамгийн бага орлоготой хэсэг 0.3 хувь буюу өчүүхэн бага хувийг эзэлж байна.

Хүснэгт-2.5 Төгсөгчдийн орлогын түвшин

	Орлогын түвшин	Тоо	Хувь	Бодит хувь	Хуримтлагдсан хувь
1	250 мянга хүртэл	2	0.2	0.3	0.3
2	251.0-500 мянга хүртэл	44	4.3	7.0	7.3
3	501.0-750 мянга хүртэл	172	16.7	27.5	34.8
4	751.0 мян-1 сая хүртэл	248	24.1	39.6	74.4
5	1-1.5 сая хүртэл	117	11.3	18.7	93.1
6	1.5 саяас дээш	43	4.2	6.9	100.0
	Нийт	626	60.7	100.0	
	Хариулаагүй	405	39.3		
	Нэгдсэн дүн	1031	100.0		

Тэрчлэн төгсөгчдийн эрхэлж буй ажлын сарын дундаж орлогыг тооцоолж үзэхэд 500 мянган хүртэл орлоготой төгсөгчид 7.3 хувийг эзэлж байгаа бол 65.2 хувь нь 750 мянгаас дээш орлоготой байна. Орлогын тухайн бүлгийг 2018 онд ХНХСИ-ээс явуулсан¹ судалгааны үр дүнтэй харьцуулж, үр дүнгийн ялгааг тооцож болох юм.




График-2.2 Төгсөгчдийн сарын дундаж мөнгөн орлогын харьцуулалт

¹ Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа. ХНХСИ. 2018

Тухайн харьцуулалтаас үзэхэд Монгол Улсын их дээд сургууль төгсөгчдийн дунд ХНХСИ- ээс эрхлэн явуулсан судалгааны үр дүнгээс МУИС-ийн төгсөгчдийн дунд явуулсан судалгааны үр дүн харьцангуй ялгаатай байна. Тухайлбал, орлогын бүлгийн доод болон дээд утгын хувьд эрс ялгаатай хувь хэмжээ байгаа ажиглаж болохын зэрэгцээ орлогын дундаж бүлгийн тархалтын хэмжээ МУИС-ийг төгссөн ажил эрхлэгчдийн хувьд илүү өндөр хувьтай байгааг харж болох юм.

Орлогын дундаж үзүүлэлтийг төгссөн сургууль тус бүрээр харьцуулж, эрэмбэлэн дараах хүснэгтэд харуулсан болно. Судалгаанд оролцогчдын сарын дундаж цалин орлогын мэдүүлснээр ОУХНУС-ийг төгсөгчдийн цалин орлого бусад МУИС-ийн бусад сургуулийг төгссөн ажил эрхлэгчдээс харьцангуй өндөр байгааг харж болох юм.

Хүснэгт-2.6 Төгсөгчдийн орлогын дундаж үзүүлэлт, сургууль тус бүрээр

Сургууль	N	Доод утга	Дээд утга	Дундаж	Хазайлт
ОУХНУС	25	500000	8000000	1906400.00	2060802.594
Хууль зүйн сургууль	68	500000	10000000	1448161.76	1692407.079
Завхан салбар сургууль	15	500000	9000000	1188666.67	2165660.133
Бизнесийн сургууль	166	320000	2500000	1057789.16	341976.055
Нийгмийн ухааны салбар	47	100000	6000000	985106.38	821562.330
Хүмүүнлэгийн ухааны салбар	91	450000	7500000	963659.34	805095.788
Байгалийн ухааны сургууль	114	170000	10000000	919508.77	923617.036
ХШУИС	98	390000	2000000	891071.43	302690.896
Орхон салбар сургууль	2	500000	600000	550000.00	70710.678
Нийт	626	100000	10000000	1065175.72	986731.119

Төгсөгчдийн орлогын дундаж үзүүлэлтийг сургууль тус бүрээр авч үзэхэд харилцан адилгүй байгааг а) төгсөгчидтэй зөвхөн утсаар холбогдож судалгааг явуулсан(зөвхөнтөгсөгчдийнхариултадтулгуурланхийсэнбашалгахбололцоогүй), б) зөвхөн орлогын хэмжээгээ илэрхийлсэн төгсөгчдийн тоо хэмжээнд тулгуурлан орлогын дунджийг тооцоолсон (тухайлбал, Орхон салбар сургуулиас нийт 34 төгсөгч хамрагдсан боловч ердөө хоёр төгсөгч орлогын хэмжээгээ илэрхийлсэн ба үүнээс дунджийг тооцоолсон) зэргийг энд харгалзаж, үнэлгээ дүгнэлт хийвэл зохино.

2.2. Төгсөгчдийн эзэмшсэн мэргэжлийн чиглэл, эрхэлж буй ажил

Монгол Улсын хэмжээнд нийт 94 төрийн өмчит болон хувийн их, дээд сургуулиудад нийт 157.625² оюутан суралцаж байгаа бөгөөд 2018 оны байдлаар Дээд боловсролын байгууллагад суралцан төгсөгчдийн 32.2³ хувь/3 суралцагч тутмын нэг/ нь төгссөн даруйдаа ажлын байртай болсон үзүүлэлт гарсан байна. БСШУЯ-ны сайдын 2014 оны А/174 тушаалаар баталсан “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”, Хичээлийн жагсаалт батлах тухай А/285 тоот тушаал, мөн А/370 тоот тушаалаар баталсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам” зэрэг баримт бичигт төгсөгчдийн эзэмших ур чадварыг хувь хүний болон мэргэжлийн ур чадвар, дадал төлөвшил, хүмүүстэй харилцах ур чадвар, мэргэжлийн хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар гэсэн бүтэц агуулгатай байхаар тогтоон “Дээд боловсролтой иргэн”-ийг төлөвшүүлэх төрийн бодлогын дагуу Их, дээд сургуулиуд хөтөлбөрийн шинэчлэлийг хийж байна. МУИС-ийн хувьд нийт долоон бүрэлдэхүүн сургуулийн 42 сургалтын тэнхим нэгжүүд, 100 гаруй мэргэжлийн хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэн төгсгөж байгаа юм.

Судалгааны үр дүнгээс үзэхэд нийт төгсөгчдийн 75.7 хувь нь ажил эрхэлдэг бол, 24.3 хувь нь ямар нэг ажил эрхлээгүй гэсэн хариултыг өгсөн байна. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар өмнө хийгдсэн түүвэр судалгааны үр дүнтэй харьцуулахад хөдөлмөр эрхлэлтийн хувь хэмжээ нэмэгдсэн байна.




График-2.3 Төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал

2015-2017 оны төгсөгчдийн түүвэр судалгаанаас үзэхэд 2015 онд төгсөгчдийн 72.8 хувь, 2016 онд төгсөгчдийн 73.4 хувь, 2017 онд төгсөгчдийн 61.8 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа тухай хариулт өгч байсан бол 2018 онд төгсөгчдийн 75.7 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа ажээ. Энэ нь нийт дөрвөн төгсөгч тутмын гурав нь ямар нэг байдлаар ажил хөдөлмөр эрхэлж байгааг илтгэн харуулж байна. 2015-2018 оны төгсөгчдийн судалгааны мэдээлэлд тулгуурлан үзэхэд 2015-2016 онд

² БСШУСЯ, Дээд боловсролын салбарын 2018-2019 оны хичээлийн жилийн статистик мэдээ. Их, дээд сургууль, коллежид суралцагчид бүс, аймаг, нийслэл 2019 оны дүн.

³ Дээд боловсролын салбарын 2017-2018 оны хичээлийн жилийн статистик мэдээллийн танилцуулга. <https://mecss.gov.mn/media/uploads/d199c4f8-e330-47b7-97f3-c110748d620a.pdf>

төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 70 хувиас дээш байгаад 2017 онд огцом буурч, 2018 онд эргээд өссөн дүр зураг харагдаж байна. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, оюутнуудын мэргэжил сонголт, мэргэжлээрээ ажиллах сонирхол, ур чадварын зэрэгцээ тухайн жилийн хөдөлмөрийн зах зээл дээрх ажил хөдөлмөрийн нийлүүлэлтээс хамаардаг онцлогтой.

Төгсөгчдийн 2015-2018 он хүртэлх хөдөлмөр эрхлэлтийн хувь хэмжээний өөрчлөлтийг дараах графикт харуулав.



График-2.4 Төгсөгчдийн ажил эрхлэлтийн хэмжээ/оноор/

2018 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс явуулсан судалгааны үр дүнгээс үзэхэд нийт их дээд сургууль төгсөгчдийн 75.2 хувь хөдөлмөр эрхэлж байгаагаас 69.1 хувь нь мэргэжлээрээ ажил хөдөлмөр эрхэлж байгаа гэсэн дүн гарчээ. Энэхүү тоон мэдээллийг улсын дундаж үзүүлэлт гэж үзвэл МУИС-ийг төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал 0.5 хувиар өндөр байгааг харж болох юм. Сүүлийн дөрвөн жилийн байдлаар төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг авч үзэхэд 2015 оноос хойш 70-аас дээш хувьтай байгаа ба цаашид өсөх зүй тогтол ажиглагдаж байна. Түүнчлэн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал эдийн засгийн өсөлт, бэлтгэгдэж буй боловсон хүчний чанар чансаа болон ажил хөдөлмөрийн нийлүүлэлт зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг гэдгийг энд дурдах нь зүйтэй.

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн дээр дурдсан үзүүлэлтийг хүйсийн онцлогоор харьцуулан авч үзье. Судалгааны үр дүнгээс үзэхэд эрэгтэй төгсөгчдийн 81.3 хувь нь ажил эрхэлж байгаа, эмэгтэй төгсөгчдийн 72.8 хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байгаа гэсэн хариулт өгсөн байна.

Хүснэгт-2.7 Төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал /хүйсээр/

			Та ажил эрхэлж байгаа юу?		Нийт
			Хувь	үгүй	
Хүйсийн байдал	эрэгтэй	Тоо	279	64	343
		Хувь	81.3%	18.7%	100.0%
	эмэгтэй	Тоо	501	187	688
		Хувь	72.8%	27.2%	100.0%
Нийт		Тоо	780	251	1031
		Хувь	75.7%	24.3%	100.0%

Хэдийгээр төгсөгчид ажил, хөдөлмөр эрхэлж буй нь чухал хэдий ч, тэд сурсан мэргэжлээрээ ажиллаж байгаа эсэхийг судлах шаардлага бий. Төгсөгчид ажил эрхэлж байгаа бол суралцсан мэргэжлээрээ ажиллаж байгаа эсэхийг судалгааны хүрээнд тодорхойлсон. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс 2018 онд явуулсан Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаанаас үзэхэд их дээд сургууль төгсөгчдийн 69.6 хувь нь эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж байна. Харин 2018 онд МУИС- ийг төгсөгчдийн хувьд 63.9 хувь нь эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж байгаа бөгөөд улсын дундаж үзүүлэлтээс дунджаас 5.7 хувиар доогуур байна.

График-2.5 Төгсөгчдийн эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж буй хувь



Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн хувьд хувиараа аж ахуй эрхэлж буй цөөнгүй хүмүүс байгаа нь дээрх үзүүлэлтэд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байж болно. Тухайлбал, хөдөлмөр эрхэлж буй оюутнуудыг эрхэлж буй ажлын төрөл, хэлбэрээр нь харьцуулан авч үзэхэд 3.9 хувь нь хувиараа аж ахуй эрхэлж байна. Цалин хөлстэй ажил эрхэлж буй төгсөгчдийг бодвол хувиараа аж ахуй эрхэлж буй төгсөгчид мэргэжлийн бус ажил төрөл эрхэлж байгаа ч, цагт баригддаггүй, сарын дундаж цалин орлого өндөр, гэр бүлийн өв залгамжилсан бизнес тул амжилт гаргах боломжтой зэрэг давуу талуудыг дурдсан байв.

Төгсөгчдийн хувийн хэвшилд ажиллах хандлага улам бүр нэмэгдэх төлөвтэй байна. Дотоодын томоохон компани, аж ахуйн нэгжүүдэд ажиллахын зэрэгцээ төгсөгчид хувиараа болон хоршиж компани аж ахуйн нэгж байгуулан ажиллах, ажил хайгч бус ажил олгогч болох явдал хааяагүй тааралдаж байна. Үүнд МУИС-аас хэрэгжүүлж буй Старт ап бизнесийн төслүүд дам ба шууд хэлбэрээр нөлөөлж буй нь дамжиггүй. Төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдлыг ажлын төрөл, хэлбэрээр авч үзэхэд дараах онцлог харагдаж байна.



График-2.6 Төгсөгчдийн эрхэлж буй ажлын төрөл, хэлбэр

Төгсөгчдийн харьцангуй олонх буюу 63.9% хувийн хэвшлийн байгууллагад ажиллаж байгаа бол төрийн байгууллагад 23.5% нь ажиллаж байна. Харин төсвийн байгууллага болон, төрийн бус байгууллага, гадаадад болон олон улсын байгууллагад ажиллагсдын тоо харьцангуй бага байгааг График 2.6-аас харж болох юм. Төгсөгчдийн 3.9 хувь нь хувиараа бизнес, аж ахуй эрхэлдэг болохоо дурдсан юм.

Төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдлыг төгссөн сургууль тус бүрээр харьцуулан авч үзэхэд дараах онцлог харагдаж байна. Хүснэгт 2.8-аас өндөр ажил эрхлэлттэй, дундаж ажил эрхлэлттэй, болон ажил эрхлэлт багатай сургуулиудыг тус тус харж болох юм.

Хүснэгт-2.8 Төгссөн сургууль ба ажил эрхлэлт

Сургууль			Та ажил эрхэлж байгаа юу?		НИЙТ
			тийм	үгүй	
ШУС	Байгалийн ухааны сургууль	тоо	134	58	192
		хувь	69.8%	30.2%	100.0%
	Нийгмийн ухааны сургууль	тоо	59	29	88
		хувь	67.0%	33.0%	100.0%
	Хүмүүнлэгийн ухааны сургууль	тоо	107	57	164
		хувь	65.2%	34.8%	100.0%
БС	Бизнесийн сургууль	тоо	212	34	246
		хувь	86.2%	13.8%	100.0%
ОУХНУС	Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль	тоо	32	4	36
		хувь	88.9%	11.1%	100.0%
ХЗС	Хууль зүйн сургууль	тоо	95	16	111
		хувь	85.6%	14.4%	100.0%
ХШУИС	Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль	тоо	94	37	131
		хувь	71.8%	28.2%	100.0%
ЗС	Завхан сургууль	тоо	21	8	29
		хувь	72.4%	27.6%	100.0%
ЭС	Эрдэнэт сургууль	тоо	26	8	34
		хувь	76.5%	23.5%	100.0%
НИЙТ		тоо	780	251	1031
		хувь	75.7%	24.3%	100.0%

Хүснэгтээс үзэхэд ажил эрхлэлт хамгийн өндөртэй гурван сургуульд ОУХНУС-88.9%, Бизнесийн сургууль-86.2%, Хууль зүйн сургууль-85.6% багтаж байна. Эдгээр сургуулийг төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь улсын дунджаас(75.2%) 10.4-13.7 хувиар өндөр байгаа юм.

ХШУИС болон Завхан, Эрдэнэт сургуулиудын төгсөгчдийн 72-76 хувь нь ажил эрхэлж байгаа нь дундаж үзүүлэлт болно. Харин ШУС-ийг төгсөгчдийн хувьд ажил эрхлэлт 67.3 хувьтай байгаа нь хамгийн бага үзүүлэлт бөгөөд улсын дунджаас 7.9 хувиар бага байна. Шинжлэх Ухааны сургуулийн салбар сургуулиудаас Байгалийн ухааны салбарыг төгсөгчдийн 69.8%, Нийгмийн ухааны салбар сургуулийг төгсөгчдийн 67.0%, Хүмүүнлэгийн ухааны салбарыг төгсөгчдийн 65.2% нь тус тус ажил эрхэлж байна. Ер нь хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй мэргэжлийн судалгаанаас үзэхэд ч тэр, боловсролын салбарын хувьд илүүдэлтэй мэргэжлийн судалгаанаас үзэхэд ч улсын хэмжээнд нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбарыг төгсөгчдийн хувьд ажилгүйдэл өндөр байгаа юм.

БҮЛЭГ ГУРАВ. ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

БСШУСЯ-ны статистик мэдээллээс үзэхэд⁴ 2018-2019 оны хичээлийн жилийн статистикийн мэдээгээр Монгол Улсад дээд боловсролын 94 байгууллага үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд 2018 онд төгсөгчдийн тоо өмнөх жилүүдээс хамгийн бага буюу 29164 оюутан төгсөж, хөдөлмөрийн зах зээлд дэвшин орсон байна.

Хүснэгт-3.1 Төгсөгчдийн судалгааны мэдээлэл

	Төгсөгчид	Дипломын дээд	Бакалавр	Магистр	Доктор
2013-2014	33,850	259	29,477	3,996	118
2014-2015	35,181	93	29,728	5,254	106
2015-2016	35,889	231	30,663	4,859	136
2016-2017	34,681	495	30,301	3,772	113
2017-2018	29,164	45	25,120	3,868	131

Хүснэгтээс үзэхэд өмнөх оноос дипломын дээд (-450)-аар, бакалавр (-5181)-ээр тус тус буурсан бол магистр (+96), доктор(+18)-аар тус тус нэмэгдсэн байв. Статистик мэдээллээс үзэхэд 2017-2018 оны хичээлийн жилд төгсөгчдийн 34.4 хувь нь төгссөн даруйдаа ажлын байртай болсон байна. Тухайн үзүүлэлтийг 2017 онтой харьцуулахад 2.2 пунктээр өссөн ажээ. Сургууль төгсөөд ажил, хөдөлмөр эрхлэх явдал олон хүчин зүйлээс хамаарна. Ажилд орох боломж хувь хүний мэдлэг, ур чадвараас гадна ажил мэргэжлийн хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт, нийлүүлэлтээс мөн хамаарч байдаг.

МУИС-ийн хувьд 2018 онд нийт 7 бүрэлдэхүүн сургуулийг 2512 оюутан төгссөн ба төгсөгчдийн сургууль төгсөөд ажилд орсон хугацаа харилцан адилгүй байна.

Хүснэгт-3.2 Сургууль төгсөөд ажилд орсон хугацаа

	Тоо	Хувь	Бодит хувь	Өсөн нэмэгдэх хувь
Шууд ажилд орсон	145	14.1	20.9	20.9
3 сарын дотор ажилд орсон	285	27.6	41.0	61.9
4-7 сарын хугацаанд хүлээж байж орсон	118	11.4	17.0	78.8

⁴ БСШУСЯ, Дээд боловсролын салбарын 2018-2019 оны хичээлийн жилийн статистик мэдээ

ТӨГСӨГЧИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

8-12 сарын хугацаанд хүлээж байж орсон	99	9.6	14.2	93.1
Нэг жил буюу түүнээс дээш хүлээж байж ажилд орсон	48	4.7	6.9	100.0
Нийт	695	67.4	100.0	
Хариулаагүй	336	32.6		
Нэгдсэн дүн	1031	100.0		

Өнөөгийн нийгэм, эдийн засгийн байдлаас хамаарч сурч боловсрохоос ажил хөдөлмөр эрхлэх нь илүү “хүндрэл, бэрхшээлтэй байдаг” гэдэгтэй хүн бүр санал нийлдэг. Суралцсан мэргэжлээрээ ажил хөдөлмөр хайх, эрхлэх явдал нэг талаас хувь хүний хичээл зүтгэл, мэргэжлийн онцлогтой холбоотой боловч, нөгөө талаас хөдөлмөрийн зах зээл, эдийн засгийн нөхцөлөөс хамаарч байдаг. Тэрчлэн ажил эрхлэлтийн хувь хэмжээ дам утгаараа дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн чанарын үнэлгээ болох учиртай.

МУИС-ийг 2018-2019 оны хичээлийн жилд төгсөгчдөөс 20.9 хувь нь суралцах үедээ болон төгссөн даруйдаа ажил хөдөлмөр эрхэлсэн байна. Харин төгсөгчдийн 41.0% буюу хамгийн их хувь нь төгссөнөөс хойш 3 сарын дотор ажил хөдөлмөр эрхлэх болсон байна. Мөн судалгааны үр дүнгээс үзэхэд төгсөгчдийн 17.0% нь 4-7 сарын хугацаанд, 9.6% нь 8-12 сарын хугацаанд ажил хөдөлмөр эрхэлсэн бол, нийт төгсөгчдийн 6.9% нь нэг жил буюу түүнээс дээш хугацаанд хүлээж байж ажил хөдөлмөр эрхэлсэн байна. Төгсөгчдийн хувьд ажилд ороход нөлөөлсөн хүчин зүйлсийг дараах байдлаар нэрлэсэн. Тухайлбал, ажилд ороход хувийн зан чанар-23.5%, төгссөн сургууль-22.7%, Ерөнхий ур чадвар-16.8% тус тус ихээхэн нөлөөлдөг эхний гурван хүчин зүйл болохыг төгсөгчид онцолжээ.

Хүснэгт-3.3 Ажилд ороход нөлөөлсөн хүчин зүйлс

Ажилд орох хүчин зүйлс		Хариултууд		Нийт хариултын хувь
		N	Хувь	
	Сурлагын дүн	119	9.1%	16.7%
	Мэргэжлийн онцлог	131	10.0%	18.4%
	Төгссөн сургууль	297	22.7%	41.7%
	Гадаад хэлний мэдлэг	146	11.1%	20.5%
	Хувийн зан чанар	308	23.5%	43.3%
	Ерөнхий ур чадвар	220	16.8%	30.9%
	Мэргэжлийн дур сонирхол, чиг баримжаа	63	4.8%	8.8%
	Өөр	26	2.0%	3.7%
Нийт		1310	100.0%	184.0%

Тэрчлэн Гадаад хэлний мэдлэг-11.1%, Тухайн мэргэжлийн онцлог-10.0%, Сурлагын дүн- 9.1% зэрэг үзүүлэлт ажил хөдөлмөр эрхлэхэд голлох нөлөөтэй хүчин зүйл гэдгийг тус тус тэмдэглэсэн байна.

Дээр дурдсан хүчин зүйлсээс гадна төгсөгчдийн хувьд ажилд орохдоо харилцан адилгүй арга, хэлбэрийг ашигласан байх бөгөөд танил талаар яриулсан, аав ээжийн эрхэлж буй ажлын байранд очсон гэх мэт хариултаас гадна өөрсдөө хайж олсон, хөдөлмөр зуучлалын байгууллагаар дамжиж олсон, дадлагажих хугацаандаа ажлын байртай болсон зэрэг хариултууд ч байна. Ажилд ороход нөлөөлсөн хүчин зүйлсийг хүйсийн онцлогоор харьцуулан харахад дараах онцлог харагдаж байна.

Хүснэгт-3.4 Ажилд ороход нөлөөлсөн хүчин зүйлс/хүйсийн байдлаар/

			Хүйсийн байдал		Нийт
			эрэгтэй	эмэгтэй	
1	Сурлагын дүн	тоо	40	79	119
		хувь	15.8%	17.2%	
2	Мэргэжлийн онцлог	тоо	46	85	131
		хувь	18.2%	18.5%	
3	Төгссөн сургууль	тоо	99	198	297
		хувь	39.1%	43.1%	
4	Гадаад хэлний мэдлэг	тоо	42	104	146
		хувь	16.6%	22.7%	
5	Хувийн зан чанар	тоо	115	193	308
		хувь	45.5%	42.0%	
6	Ерөнхий ур чадвар	тоо	95	125	220
		хувь	37.5%	27.2%	
7	Мэргэжлийн дур сонирхол, чиг баримжаа	тоо	18	45	63
		хувь	7.1%	9.8%	
8	Бусад хүчин зүйл(танил тал гм)	тоо	10	16	26
		хувь	4.0%	3.5%	

Хүйсийн хувьд харьцуулан авч үзэхэд ажилд ороход харилцан адилгүй хүчин зүйлс нөлөөлдөг байна. Тухайлбал, эрэгтэй төгсөгчдийн хувьд **1) хувийн зан чанар-45.5%, 2)төгссөн сургууль-39.1%, 3)ерөнхий ур чадвар-37.5%**, ихээхэн нөлөөлдөг бол, эмэгтэй төгсөгчдийн хувьд **1)төгссөн сургууль-43.1%, 2)хувийн зан чанар-42.0%, 3)ерөнхий ур чадвар-27.2%** тус тус нөлөөлсөн байна. Тэрчлэн төгссөн сургууль болон хувийн зан чанарыг эрэгтэй эмэгтэй аль аль төгсөгчийн хувьд ойролцоо нөлөөлсөн чухал хүчин зүйл гэж үзсэн бол Ерөнхий ур чадварыг эрэгтэй төгсөгчид эмэгтэйчүүдээс 10.3 хувиар илүү үнэлсэн байгааг харж болох юм.

Төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, ажил олгогчдын зүгээс төгсөгчдийн онолын мэдлэг төдийгүй ерөнхий ур чадварт тавих шаардлагыг сургалтын хөтөлбөрт тусган ажиллах шаардлагатай. Өнөөдөр боловсролын зах зээлд чанартай суралцсан төгсөгчид хөдөлмөрийн зах зээлд ерөнхий ур чадвараар “маруухан” байгааг шат шатандаа хүлээн зөвшөөрч байна. Энэ талаар Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаанд дэлгэрэнгүй авч үзсэн болно.


3.1. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, цалин орлого

Ажил эрхлэгчдийн хувьд ажлаа солих, өөрчлөх эсвэл ажлын байрандаа тогтвортой ажиллах нэгэн чухал үзүүлэлт бол цалин орлогын хэмжээ болно. Нийт 1031 төгсөгчдөөс 620 гаруй нь сарын дундаж орлогын үзүүлэлтээ ойролцоогоор илэрхийлсэн. Судалгаанд хамрагдсан МУИС-ийг төгсөгчдийн сарын дундаж мөнгөн орлого 1065.1 мянган төгрөг байна. Ажил эрхэлж буй төгсөгчид сард дунджаар хамгийн багадаа 100 мянга, хамгийн ихдээ 10 сая хүртэл төгрөгийн орлого олдог гэсэн хариулт өгсөн байна. Харин ямар нэг байдлаар ажил эрхэлдэггүй буюу түр ажил эрхэлж буй 12 төгсөгчийн хувь сард 450 мянгаас 2 сая хүртэл төгрөгийн орлоготой гэсэн хариулт өгсөн.

Хүснэгт-3.5 Ажил эрхлэлтийн байдал ба орлогын дундаж

Та ажил эрхэлж байгаа юу?	N	Minimum	Maximum	Mean	Std. Deviation
тийм	614	100000	10000000	1072671.01	993170.913
үгүй	12	450000	2000000	681666.67	433628.105

Хүснэгтээс харвал ажил эрхэлдэг төгсөгчдийн сарын дундаж мөнгөн орлого 1072.7 мянган төгрөг байхад ажил эрхэлдэггүй буюу түр ажил эрхэлдэг төгсөгчдийн хувьд 681.6 мянган төгрөгийн орлоготой, 1.6 дахин бага байна. Хүйсийн хувьд харьцуулж үзэхэд эрэгтэй,



эмэгтэй төгсөгчдийн сарын дундаж орлогын хэмжээ эрс ялгаатай байв. Эрэгтэй төгсөгчдийн хувьд сарын дундаж орлого 1255.4 мянган төгрөг байхад эмэгтэй төгсөгчид сард дунджаар 968.5 мянган төгрөгийн орлого олдог байна. Сарын дундаж орлогын зөрүүг тооцож үзэхэд 286.8 мянган төгрөгөөр эрэгтэй төгсөгчид илүү орлоготой ажиллаж байна. Төгсөгчдийн хувьд ажлын туршлага бага, ажил эрхлэх боломж хязгаарлагдмал, мэргэжлийн чиглэлээрх ажил олдохгүй нөхцөлд хөдөлмөрийн цалин урамшуулал бага ч гэсэн олдсон ажлыг эрхлэх амьдралын

шаардлагатай зүй ёсоор “нүүр тулдаг”. Харин тодорхой хугацааны дараа туршлага сууж, ажлын дөртэй болсноор нийгмийн хангамж, цалин хөлс ахиу, ажил эрхлэх боломж нээгддэг талаар төгсөгчид дурдаж байлаа.

Дээрх бүлгүүдийн сарын дундаж орлогын хэмжээний ялгаатай байдлыг үл хамаарах Т шалгуурыг ашиглан тооцож үзэв. Нийтлэг хэрэглэгддэг, хоёр хувьсагчийн статистик шалгуур тул нийгмийн ухаанд илүү түгээмэл хэрэглэгддэг. Хоёр хэмжээст параметрийн шалгуур бөгөөд нэг ижил хугацаанд (нэг түүвэр-хоёр бүлэг) судлагдаж байгаа хоёр үл хамаарах хувьсагчийн дунджийн хоорондын ялгааг илрүүлэх, энэхүү ялгаа статистик ач холбогдолтой эсэхийг тогтооход хэрэглэгддэг.

Хүснэгт-3.6 Үл хамаарах Т шинжүүр, хүйсийн ялгаа ба орлогын дундаж үзүүлэлт

	Independent Samples Test								
	Levene's Test for Equality of Variances		t-test for Equality of Means						
	F	Sig.	t	df	Sig. (2-tailed)	Mean Difference	Std. Error Difference	95% Confidence Interval of the Difference	
								Lower	Upper
Сарын дундаж цалин орлого	15.103	.000	-3.469	624	.001	-286880.672	82702.955	-449290.498	-124470.845
			-2.948	284.378	.003	-286880.672	97298.790	-478397.865	-95363.478

Тус шинжилгээнээс үзэхэд эрэгтэй, эмэгтэй хүйсийн бүлгийн хувьд дунджийн ялгаа статистик ач холбогдолтой гарч байгаа нь үл хамаарах тухайн бүлгүүдийн орлогын хэмжээ хоорондоо эрс ялгаатай байгааг харуулж байна. Судалгааны мэдээлэл, үр дүнг харьцуулж холбоо хамаарал эрэх, корреляцын шинжилгээг ажил эрхлэлт, орлого ба голч онооны үзүүлэлтэд тулгуурлан хийсэн болно.

Хүснэгт-3.7 Корреляцын шинжилгээний үр дүн

		Та ажил эрхэлж байгаа юу?	Орлогын дундаж	Голч оноо
Та ажил эрхэлж байгаа юу?	Pearson Correlation	1	-.146**	-.069*
	Sig. (2-tailed)		.000	.026
	N	1031	626	1031
Орлогын дундаж	Pearson Correlation	-.146**	1	.073
	Sig. (2-tailed)	.000		.068
	N	626	626	626
Голч оноо	Pearson Correlation	-.069*	.073	1
	Sig. (2-tailed)	.026	.068	
	N	1031	626	2000

** . Correlation is significant at the 0.01 level (2-tailed). * . Correlation is significant at the 0.05 level (2-tailed).

Шинжилгээний үр дүнгээс үзэхэд голч оноо ба ажил эрхлэлт хамааралтай ($r < 0.05$), ажил эрхлэлт ба орлогын дундаж өндөр хамааралтай ($r < 0.01$) болох нь харагдаж байна. Ажил эрхлэхгүй байх нь орлогын хэмжээнд сөргөөр нөлөөлдөг болох нь тодорхой, харин голч оноо бага байх тусам ажил эрхлэлтийн хувь хэмжээ буурахад нөлөө үзүүлдэг гэсэн хамаарал ажиглагдаж байгаа нь сонирхол татаж байна. Үүнээс үзэхэд сурлагын голч дүн ямар нэг байдлаар ажил хөдөлмөр эрхлэхэд нөлөө үзүүлдэг байна. Голч оноо болон орлогын дундаж үзүүлэлтийн хувьд Sig. (1-tailed)=0.320 буюу ($r > 0.05$) байгаа тул ачхолбогдолгүй буюу тодорхой хамаарал байхгүй гэж дүгнэж болох юм.

Тухайн жилд төгсөгчдийн голч оноо болон ажил эрхлэлт, сарын дундаж мөнгөн орлогын үзүүлэлтийг доорх хүснэгтэд харуулав. Ихэнх төгсөгчдийн хувьд сарын дундаж орлогоо ойролцоогоор илэрхийлж хариулт өгсөн ба мөн хариулт өгөхөөс татгалзсан тохиолдол гарч байлаа.

Хүснэгт-3.8 Мэргэжлийн чиглэл: голч оноо, ажил эрхлэлт, сарын дундаж орлого

Мэргэжлийн чиглэл	Голч оноо	Та ажил эрхэлж байгаа юу?	Сарын дундаж цалин орлого
Антропологи	2.7375	2.00	хариулт өгөөгүй
Археологи	2.9000	2.00	хариулт өгөөгүй
Багш, байгалийн ухааны боловсрол	2.7656	1.50	1582090.91
Багш, биологи-байгаль шинжлэл	2.9000	1.00	900000.00
Багш, гадаад хэлний боловсрол	3.1200	1.48	873333.33
Багш, математикийн боловсрол	2.8909	1.55	780000.00
Багш, монгол хэл уран зохиол	3.0348	1.39	1225000.00
Багш, монгол хэл-уран зохиолын боловсрол	3.3000	1.50	450000.00
Багш, монгол хэл-эх бичиг	2.7000	1.00	900000.00
Багш, нийгмийн ухааны боловсрол	3.2538	1.46	600000.00
Багш, химийн боловсрол	2.4500	1.00	750000.00
Байгалийн нэгдлийн хими	2.3000	1.00	хариулт өгөөгүй
Байгаль ашиглалт, хяналт	2.7000	1.00	650000.00
Байгаль орчны нөхөн сэргээлт	2.3500	1.50	1000000.00
Байгаль орчныг зайнаас тандан судлал	2.8083	1.42	710000.00
Байгаль орчныг хамгаалагч	2.7375	1.25	950000.00
Банк	3.0083	1.33	1022857.14
Бизнесийн менежмент	2.2667	1.33	750000.00
Бизнесийн сэтгэл судлал	2.7500	1.00	1450000.00
Био-инженерчлэл	2.7000	1.29	768000.00

ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Биологи	2.8231	1.31	708571.43
Биологийн нөөцийн менежмент	2.4000	1.00	1000000.00
Биотехнологи	3.1222	1.33	825909.09
Биохими	2.6667	1.00	783333.33
Гадаад хэл, орон судлал	3.0016	1.43	1110433.33
Гадаад хэлний орчуулга	2.9412	1.12	863636.36
Газар зохион байгуулалт	3.1650	1.20	833769.23
Газарзүй	2.4200	1.40	583333.33
Геологи	2.8700	1.40	733333.33
Геофизик	2.5857	1.43	1387500.00
Даатгал	2.4000	1.30	784666.67
Даатгалын эдийн засаг	2.1800	1.00	800000.00
Зочлох үйлчилгээ	2.7000	1.00	633333.33
Компьютерын график дизайн	3.0000	1.00	1500000.00
Компьютерын програм хангамж	2.2000	1.33	900000.00
Компьютерын сүлжээ	2.3727	1.18	944444.44
Маркетинг	2.7188	1.19	1065000.00
Маркетинг менежмент	2.0000	1.00	хариулт өгөөгүй
Математик	3.0200	1.20	695000.00
Математик, хэрэглээний	2.0000	1.00	1000000.00
Материал судлал	2.6800	1.80	1000000.00
Менежмент	2.7400	1.08	1074583.33
Менежмент, банкны	2.4000	1.20	873333.33
Менежмент, биржийн худалдаа	2.7000	1.00	1000000.00
Менежмент, зочид буудал,	2.7000	1.00	800000.00
Менежмент, маркетингийн менежер	2.1333	1.00	700000.00
Менежмент, олон улсын худалдаа	2.2000	1.33	1000000.00
Менежмент, санхүүгийн	2.8300	1.00	1157142.86
Менежмент, үйлдвэрлэлийн	2.7000	1.00	1000000.00
Менежмент, худалдааны	2.2000	1.00	900000.00
Монгол хэл, уран зохиол	3.6000	2.00	хариулт өгөөгүй
Монгол хэл, эх бичиг судлал	2.5000	2.00	хариулт өгөөгүй
Монгол-Англи хэл, судлал	2.8000	1.00	600000.00
Мэдээллийн систем	2.9000	1.43	1050000.00
Мэдээллийн технологи	3.1000	1.40	933333.33
Нано шинжлэх ухаан, инженерчлэл	2.7800	1.00	780000.00
Нефтийн хими	2.2000	2.00	хариулт өгөөгүй

ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Нийгмийн ажил	2.8778	1.22	1342857.14
Нябо, хяналт шалгалт	2.4800	1.20	900000.00
Нягтлан бодох бүртгэл-Орхон	2.7640	1.28	813571.43
Нягтлан бодох бүртгэл-БС	2.9955	1.16	1150000.00
Нягтлан бодох бүртгэл-Завхан	2.1000	2.00	хариулт өгөөгүй
Ой судлал	2.5000	1.33	635000.00
Ойн аж ахуй	2.8000	2.00	хариулт өгөөгүй
Олон улс судлал	2.3000	1.00	850000.00
Олон улсын харилцаа	3.2697	1.12	1701363.64
Олон улсын эдийн засаг	2.4000	2.00	хариулт өгөөгүй
Олон улсын эдийн засгийн харилцаа	3.2000	1.00	1500000.00
Олон улсын эрхзүй	3.1727	1.27	1212500.00
Орос хэл, шинжлэл	2.5000	1.00	500000.00
Програм хангамж	3.0500	1.21	1181818.18
Санхүү	3.1306	1.08	1151851.85
Санхүү-эдийн засаг	2.6875	1.00	2033333.33
Санхүү, банк	2.9000	1.00	1000000.00
Санхүү, эдийн засаг	2.5000	1.67	хариулт өгөөгүй
Санхүүгийн менежмент-Мэдээлэл зүй	2.3375	1.13	1050000.00
Социологи	2.7200	1.60	750000.00
Статистик	2.5833	1.22	854642.86
Статистик, хэрэглээний	1.8000	1.00	780000.00
Сэргээгдэх эрчим хүч	3.1333	1.17	840000.00
Сэтгүүл зүй	3.1900	1.30	870000.00
Сэтгэл судлал	3.1364	1.23	845454.55
Татварын эдийн засаг, нябо	1.9000	1.00	600000.00
Төрийн захиргааны менежмент	3.3500	1.00	4365000.00
Түүх	2.5667	1.33	845000.00
Улс төр судлал	2.9636	1.09	1100000.00
Ус судлал	2.6000	1.00	390000.00
Физик	2.8400	1.40	750000.00
Физик-Электроник	2.3000	1.00	1200000.00
Философи	2.9500	1.17	700000.00
Хатуу биеийн материал судлал	2.3000	1.00	1400000.00
Хими	2.2750	1.00	850000.00
Химийн инженерчлэл	3.0400	1.60	850000.00

ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Хот ба бүс нутаг төлөвлөлт	3.1500	1.25	700000.00
Хот ба бүс нутгийн төлөвлөлт	3.1154	1.08	896666.67
Худалдаа	2.6375	1.13	848000.00
Хүн ам зүй	2.7000	1.00	1000000.00
Хүнсний хими	2.1000	1.00	700000.00
Хүрээлэн буй орчин судлал	2.9571	1.29	771428.57
Хэл шинжлэл (Герман)	3.0000	1.00	975000.00
Хэл шинжлэл (Монгол хэл)	3.8000	1.00	700000.00
Хэл шинжлэл (Орос)	2.9000	1.00	хариулт өгөөгүй
Хэл, уран зохиол (Монгол судлал)	3.3000	1.00	510000.00
Хэрэглээний геофизик	2.3429	1.00	1071428.57
Хэрэглээний математик	2.5714	1.43	766666.67
Хэрэглээний хими	2.0000	1.00	800000.00
Хятад хэл, шинжлэл	2.5000	1.00	750000.00
Цаг уур	2.2250	1.00	1000000.00
Цөмийн эрчим хүч	3.6000	1.00	640000.00
Шашин судлал	2.8750	1.25	750000.00
Эдийн засаг	3.0167	1.08	955000.00
Эдийн засаг, статистик	2.6000	1.33	875000.00
Эдийн засгийн мэдээлэл	2.0000	1.00	1000000.00
Экологи	3.0200	1.20	945285.71
Электроник	2.7000	1.00	750000.00
Эрдэс материалын хими	2.4000	2.00	хариулт өгөөгүй
Эрх зүй	2.9780	1.13	1462890.63
Ерөнхий дундаж	2.8783	1.24	1065175.72

Тайлбар: (1.5 ≤ажил эрхэлдэг, 1.5> бол ажил эрхэлдэггүй)

Хүснэгтэд дурдсан мэдээллийг тайлж уншихдаа дараах зүйлийг анхаарна уу?.

1. Тухайн хүснэгтэд зөвхөн судалгаанд хамрагдсан оюутнуудын төгссөн хөтөлбөр, мэргэжлийн чиглэлийг авч үзсэн бөгөөд сурлагын голч дүн, ажил эрхлэлтийн байдал болон орлогын дундаж үзүүлэлтийг харьцуулсан болно.
2. Тус мэдээлэл зөвхөн ерөнхий чиг хандлагыг харуулах ба мэргэжлийн хөтөлбөрийг харьцуулах үзүүлэлт болохгүй.
3. Энэ нь зөвхөн тухайн нөхцөлд утсаар холбогдсон төгсөгчдөөс авсан тул ажил эрхэлж буй эсвэл эрхлээгүй гэдгээр тухайн хөтөлбөрийг үнэлэх, цалин хангамж өндөр эсвэл бага гэсэн мэргэжлийн давуу болон сул талыг илэрхийлэх шууд үзүүлэлт болохгүй.

3.2. Төгсөгчдийн ажилгүйдэл, түүний шалтгаан

Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 24.3 хувь нь ямар нэг ажил төрөл эрхлээгүй байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс эрхлэн явуулсан судалгааны үр дүнгээс үзэхэд Их дээд сургууль төгсөгчдийн 24.8 хувь нь ямар нэг хөдөлмөр эрхлээгүй,

30.9 хувь нь мэргэжлээрээ ажиллаагүй дүн мэдээ бий. Ерөнхийдөө төрөл хайх явцад дараах хүндрэл бэрхшээлүүд их дээд сургууль төгсөгчдөд тулгардаг байна. Үүнд:

Хүснэгт-3.9 Ажил хайх явцад гардаг хүндрэл, бэрхшээл

№	Үзүүлэлт	ИДС төгсөгчдийн хувьд
1	Ажлын туршлага дутах	22.7
2	Ажлын байрны мэдээллийн хомстол	17.3
3	Мэргэжилд тохирох ажил олдохгүй	16.8
4	Гадаад хэлний мэдлэг	13.6
5	Цалин хөлс	8.9
6	Боловсрол, ур чадвар, мэргэжлийн үл нийцэл	6.2
7	Ажлын орчин, ажлын цаг	5.3
8	Нас, хүйсийн ялгаварлал	3.5
9	Санхүүгийн хүндрэл	1.8
10	Ар гэрийн асуудал	1.9
11	Зан төлөв, хүсэл сонирхолоо тодорхойлох чадвар	0.3
12	Өөртөө итгэлгүй/ирээдүйд/ байдал	1.3
13	Гадаад дүр төрх, биеийн хөгжил	0.3
	Нийт	100.0

МУИС-ийн төгсөгчдийн дунд явуулсан судалгаагаар дээрх судалгаанаас харьцангуй өөр, онцлог нөхцөл ажиглагдаж байна. Юуны өмнө одоогийн байдлаар ажил эрхлээгүй байгаа

МУИС-ийг төгсөгчдийн хувьд ажил эрхлэхгүй байгаа үндсэн шалтгаанд ар гэрийн шалтгаан илүү өндөр хувь 22.1% эзэлж байна. Тухайн ажил эрхлэхгүй байгаа шалтгааныг дурдсан ялангуяа эмэгтэй төгсөгчдийн хувьд хүүхэд төрүүлсэн гэсэн хариулт зонхилж байгаагийн дээр хувиараа хөдөлмөр эрхэлдэг, гадаадад сурч байгаа(Австрали, Япон, Канад, Тайван гм) зэрэг хариултууд түгээмэл байв.

Түүнчлэн судалгаанд хамрагдсан төгсөгчдийн удаах хэсэг нь үргэлжлүүлэн суралцаж байгаагаа илэрхийлсэн болно. Тухайн хариултыг судалгаанд оролцогчдын 21.8 хувь нь өгсөн юм. Мөн судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 14 хувь нь гадаад руу гарч ажиллах буюу сурахаар явсан гэсэн хариулт өгсөн юм. Ажил эрхлэхгүй байгаа 10 төгсөгч тутмын нэг нь мэргэжлээрээ ажил хайсан боловч олдохгүй байгаа

ТӨГСӨГЧИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

гэжээ. Ялангуяа хөдөө орон нутгийн төгсөгчдийн хувьд ажлын байрны олдоц муу, мэргэжлийн ажил хийх боломж бололцоо тааруу, хүртээмж муу байгаа юм. Үүнээс хамаарч хүн амын хот суурин руу шилжих хөдөлгөөн ажил хөдөлмөр эрхлэх үйл явцтай уялдаатай байна.

Хүснэгт-3.10 МУИС-ийг төгсөгчдийн хувьд ажил эрхлэхгүй байгаа шалтгаан

		Хариулт		Хариулсан хувь
		N	%	
1	Ар гэрийн шалтгаанаар	79	22.1%	38.7%
2	Үргэлжлүүлэн суралцаж байгаа	78	21.8%	38.2%
3	Гадаад орон руу явсан	50	14.0%	24.5%
4	Мэргэжлээрээ ажил хайсан боловч олдохгүй	37	10.3%	18.1%
5	Эрүүл мэндийн шалтгаанаар	33	9.2%	16.2%
6	Ажил хайгаагүй	22	6.1%	10.8%
7	Ажиллах шаардлагагүй	14	3.9%	6.9%
8	Ажлын байрны шаардлага хэт өндөр	8	2.2%	3.9%
9	Цалин бага	7	2.0%	3.4%
10	Мэргэжилдээ дур сонирхолгүй	4	1.1%	2.0%
11	Ажлын ачаалал их	3	0.8%	1.5%
12	Мэргэжлийн мэдлэг, ур чадвар дутмаг	2	0.6%	1.0%
13	Бусад	21	5.9%	10.3%
	Нийт	358	100.0%	175.5%

Судалгааны үр дүнгээс эрүүл мэндийн шалтгаанаар ажил хөдөлмөр эрхлэхгүй байгаа-9.2%, ажил хайгаагүй-6.1%, ажиллах шаардлагагүй-3.9%, ажлын байрны шаардлага хэт өндөр- 2.2%, цалин бага-2.0% мэргэжилдээ дур сонирхолгүй-1.1% зэрэг хариултыг өгсөн байна.

Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн өгсөн хариултад тулгуурлан төгссөн сургуулиудын ажил хөдөлмөр эрхлэхгүй байгаа төгсөгчдийн хувь хэмжээг дараах байдлаар эрэмбэлэн харуулж болох юм.

- Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль -11.1%
 - Бизнесийн сургууль -13.8%
 - Хууль зүйн сургууль -14.4%
 - Эрдэнэт сургууль -23.5%
 - Завхан сургууль -27.6%
 - Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль -28.2%
 - Шинжлэх ухааны сургууль -32.7%
- (БУС-30.2%, НУС-33.0%, ХУС-34.8%)

Тус эрэмбээс үзэхэд ОУХНУС, Бизнесийн сургууль, ХЗС-ийг төгсөгчдийн 11.1-14.4 хувь нь ямар нэгэн ажил эрхлээгүй байгааг харж болно. Харин ШУС-ийн Нийгмийн ухаан, байгалийн ухаан, хүмүүнлэгийн ухааны сургуулийг төгссөн бараг гурван төгсөгч тутмын нэг нь, ХШУИС, Завхан сургуулийн дөрвөн төгсөгч тутмын нэг нь тус тус ажил, хөдөлмөр эрхлээгүй байгааг дээрх эрэмбэлсэн үзүүлэлтээс харж болно.

Тухайн салбар сургуулийг төгсөгчдийн мэргэжлээрээ ажиллаж буй хувь хэмжээг харьцуулан авч үзэхэд дараах онцлог харагдаж байна.

Хүснэгт-3.11 Мэргэжлийн ажлаа хийж байгаа эсэх?, төгссөн сургуулиар

			Мэргэжлийн ажлаа хийж байгаа юу?		Нийт
			тийм	үгүй	
Сургууль	Байгалийн ухаан	тоо	89	45	134
		хувь	66.4%	33.6%	100.0%
	Нийгмийн ухаан	тоо	35	32	67
		хувь	52.2%	47.8%	100.0%
	Хүмүүнлэгийн ухаан	тоо	50	55	105
		хувь	47.6%	52.4%	100.0%
	Бизнесийн сургууль	тоо	173	73	246
		хувь	70.3%	29.7%	100.0%
	ОУХНУС	тоо	13	15	28
		хувь	46.4%	53.6%	100.0%
	ХЗС	тоо	74	35	109
		хувь	67.9%	32.1%	100.0%
	Завхан сургууль	тоо	11	9	20
		хувь	55.0%	45.0%	100.0%
	ХШУИС	тоо	78	25	103
		хувь	75.7%	24.3%	100.0%
	Эрдэнэт сургууль	тоо	16	16	32
		хувь	50.0%	50.0%	100.0%
Нийт		тоо	539	305	844
		хувь	63.9%	36.1%	100.0%

Ерөнхийдөө гурван төгсөгч оюутан тутмын нэгээс илүү нь эзэмшсэн мэргэжлээсээ өөр ажил эрхэлж байна.

Ажил эрхлэлтийн түвшин харьцангуй бага байгаа ШУС-ийг төгсөгчдийн хувьд ажил эрхлэхгүй байгаа шалтгааныг бүлэглэн авч үзэхэд дараах үндсэн шалтгаанууд зонхилж байна. Үүнд:

- Ар гэрийн шалтгаанаар ажил эрхлэхгүй байгаа-25.7%
- Үргэлжлүүлэн суралцаж байгаа-21.0%
- Гадаад руу сурах, ажиллахаар явсан-15.2%
- Мэргэжлээрээ ажил хайсан боловч олдохгүй-11.2%
- Эрүүл мэндийн шалтгаанаар ажил эрхлээгүй-9.4%

зэрэг шалтгаанууд нийтлэг тохиолдож байна. Тус сургуулийн хувьд сургалтын хөтөлбөр, бэлтгэж буй мэргэжлийн хөдөлмөрийн зах зээлд дахь эрэлт хэрэгцээ, төгсөж буй мэргэжилтний мэдлэг, ур чадварт нарийвчилсан шинжилгээ хийх шаардлагатай гэж үзэж байна.

БҮЛЭГ ДӨРӨВ. ИХ СУРГУУЛИЙН ХӨТӨЛБӨР БА ҮЙЛЧИЛГЭЭНД ӨГСӨН ТӨГСӨГЧДИЙН ҮНЭЛГЭЭ

МУИС-ийг төгсөгчидтэй холбогдон суралцах хугацаанд үзүүлсэн сургалтын хөтөлбөр болон үйлчилгээнд үнэлгээ, дүгнэлт авсан болно. Хөтөлбөрийн үнэлгээ бол хөтөлбөрийг сайжруулах зорилгоор оюутан, багшлах бүрэлдэхүүн, ажил олгогчидтой холбогдох, хөтөлбөрийг цаашид тасралтгүй хөгжүүлэхэд шаардагдах эргэх холбоог бий болгох тогтолцоо (Д.Ариунболор, Р.Мядагмаа, П.Туул ба бусад, 2017) юм. Гадаадын их дээд сургуулийн жишгээс үзэхэд сургалтын үйл ажиллагааны үнэлгээг “Evaluation” ба “Assessment” гэсэн хоёр хэлбэрээр илэрхийлдэг (Д.Ариунболор ба бусад, 2017). “Evaluation” үнэлгээг хөтөлбөрт ерөнхий үнэлгээ өгөх, чанарын баталгааг хийхэд ашигладаг. “Assessment” үнэлгээг суралцах үйл ажиллагааны мэдлэг, чадвар, чадамж, зөөлөн ур чадварууд (багаар ажиллах, хувь хүний харилцаа гэх мэт), онолыг хэрэглээний түвшинд бүрэн эзэмших байдлыг тодорхойлоход тус тус ашигладаг байна.

Хөтөлбөрийн үнэлгээ нь өргөн цар хүрээтэй хөтөлбөрийн ерөнхий үнэ цэнийг харуулсан үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл тухайн хөтөлбөр хэтийн зорилгодоо хүрэх явцад хэрхэн ахиц дэвшил гарч байгааг нотлон харуулахын тулд хичээлийн үнэлгээ, сургагч багшийн санал бодол, элсэгч, төгсөгчидтэй хийх ярилцлага, хөндлөнгийн үнэлгээний тайлан, төгсөгчдийн мөшгих судалгаа болон ажил олгогчдоос авах сэтгэл ханамжийн судалгаа зэрэг олон тооны үр дүнд тулгуурладаг. Хөтөлбөрийн үнэлгээний явцад цуглуулсан нотлох баримт нь тухайн хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах үндэс болдог. Энэхүү тайланд мөшгих судалгааны хүрээнд сургалтын хөтөлбөрийн сул ба давуу талын талаар төгсөгчид ерөнхий үнэлгээ өгсөн ба тухайн санал бодлыг тусгасан болно.

4.1. МУИС-ийн хөтөлбөрийн давуу болон сул талыг үнэлсэн байдал

Төгсөгчид суралцсан хөтөлбөрийн давуу болон сул талыг харилцан адилгүй үнэлсэн байна. Төгсөгчдийн зүгээс элсэлт ба эхлэн суралцах үйл явц, сурах үйл явц, төгсөх үйл явцтай холбоотой сул талуудыг дурдсаныг сургууль тус бүрээр нарийвчлан харуулж болох юм. Судалгаанд Шинжлэх ухааны сургууль, Бизнесийн сургууль, Завхан сургууль, Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль, Хууль зүйн сургууль, Эрдэнэт сургууль,

Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийг төгсөгчид сургууль тус бүрийн давуу болон сул тал, сайжруулах шаардлагатай хүчин зүйлсийг үнэлсэн болно.

ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ

Шинжлэх ухааны сургууль (ШУС)-ийн 444 төгсөгч судалгаанд оролцлоо. ШУС-ийн давуу талыг тодорхойлсон 243 оролцогчдын 86 нь багшийн хичээлээ заах ур чадвар сайн, оюутнуудтай тулж харилцах, тэднийг идэвхжүүлэх, хөгжүүлэх тал дээр анхаарч ажилладаг гэсэн байна.

СУЛ ТАЛ			
№	Агуулга	Саналын	
		Тоо	Хувь
1	Хичээлийн хөтөлбөрийг хөгжүүлэх шаардлагатай	128	63.4
2	Багшийн ур чадвар, туршлагыг нэмэгдүүлэх, ажилчдын харилцааг сайжруулах	23	11.4
3	Sisi систем хөгжүүлэх	20	9.9
4	Тухайн мэргэжлийн нийгэм дэх хэрэгцээ, эрэлт бага, төлбөр өндөр	17	8.4
5	Анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн	14	6.9
	Нийт	202	100
ДАВУУ ТАЛ			
1	Хичээлийн хөтөлбөр сайн	124	51.0
2	Багшийн ур чадвар, туршлага сайн	86	35.4
3	Сургуулийн нэр хүнд өндөр	20	8.2
4	Анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн хангалттай	8	3.3
5	Тухайн мэргэжлийн нийгэм дэх хэрэгцээ, эрэлт их байгаа	5	2.1
	Нийт	243	100
САЙЖРУУЛАХ ХҮЧИН ЗҮЙЛС			
1	Хичээлийн хөтөлбөр	120	70.6
2	Анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн	30	17.6
3	Sisi систем	11	6.5
4	Багш, ажилчдын харилцаа, ур чадвар, туршлага	9	5.3
	Нийт	170	100

ШУС-ийн 2018 оны 202 төгсөгч сургуулийнхаа сул талыг тодорхойлсон бөгөөд нийт судалгаанд оролцогчдын 128 нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн, болон чөлөөт сонголтын хичээлийн агуулга, уялдаа холбоо, оновчтой төлөвлөгөө, хавар, намрын хичээл сонголт, элсэлт, квот, ангид хуваах систем, анги

удирдсан багшийн оюутнуудтай ажиллах систем, оюутны хичээлээс гадуурх сурч хөгжих хөтөлбөр зэргийг илүү хөгжүүлэх шаардлагатай гэж үзсэн байна.

БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ

Бизнесийн сургууль (БС)-ийн 248 төгсөгч судалгаанд оролцсоноос сургалтын хөтөлбөрийн давуу болон сул талыг үнэлж 24 төгсөгч хөтөлбөрийн давуу болон сул талыг үнэлж санал өгсөн байна. Сургуулийн хөтөлбөрийн сул талыг 6 төгсөгч, давуу талыг 3 төгсөгч, сайжруулах хүчин зүйлс дээр нийт 12 төгсөгч тус бүр саналаа илэрхийлжээ. Хичээлийн хөтөлбөр, сургуулийн нэр хүнд өндөр, анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн хангалттай гэсэн давуу талуудыг төгсөгчид дурдсан байна.

СУЛ ТАЛ		
№	Агуулга	Саналын тоо
1	Багшийн ур чадвар, туршлага нэмэгдүүлэх, ажилчдын харилцааг сайжруулах	2
2	Анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн	2
3	Хичээлийн хөтөлбөрийг хөгжүүлэх шаардлагатай	1
4	Тухайн мэргэжлийн нийгэм дэх хэрэгцээ, эрэлт бага, төлбөр өндөр	1
	Нийт	6
ДАВУУ ТАЛ		
1	Хичээлийн хөтөлбөр сайн	1
2	Сургуулийн нэр хүнд өндөр	1
3	Анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн хангалттай	1
	Нийт	3
САЙЖРУУЛАХ ХҮЧИН ЗҮЙЛС		
1	Хичээлийн хөтөлбөрийг сайжруулах, үүнд: мэргэжлийн хичээлийн кредит цагийг нэмэгдүүлэх, дадлага хийх хугацааг уртасгах	12
2	Sisi систем	1
3	Багш, ажилчдын харилцаа, ур чадвар, туршлага	2
	Нийт	15

Харин багшийн ур чадвар, туршлага, анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн, хичээлийн хөтөлбөр болон тухайн мэргэжлийн нийгэм дэх эрэлт хэрэгцээ, төлбөр өндөр зэргийг сул тал гэж үзжээ.

БС-ийн төгсөгчид нь сургуулийн сайжруулах хүчин зүйлсийн нэгдүгээрт мэргэжлийн хичээлийн кредит цагийг нэмэгдүүлэх, дадлага хийх хугацааг уртасгах, нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн саналтай байна.

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ

Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль (ОУХНУС)-ийн 36 төгсөгч судалгаанд оролцсоноос хорь гаруй төгсөгч сургалтын хөтөлбөрийн давуу болон сул талыг үнэлсэн байна. Сургалтын хөтөлбөрийн давуу талыг үнэлж нийт 21 төгсөгч саналаа өгсөн ба хичээлийн хөтөлбөр, багшийн ур чадвар туршлага харьцангуй сайн, анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн хангалттай сайн гэж үзжээ.

СУЛ ТАЛ		
№	Агуулга	Саналын тоо
1	Хичээлийн хөтөлбөрийг хөгжүүлэх шаардлагатай	14
2	Sisi систем хөгжүүлэх	2
3	Багшийн ур чадвар, туршлага нэмэгдүүлэх, ажилчдын харилцааг сайжруулах	2
	Нийт	18
ДАВУУ ТАЛ		
1	Хичээлийн хөтөлбөр сайн	17
2	Багшийн ур чадвар, туршлага сайн	3
3	Анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн хангалттай	1
	Нийт	21
САЙЖРУУЛАХ ХҮЧИН ЗҮЙЛС		
1	Хичээлийн хөтөлбөрийг сайжруулах, үүнд: хичээлийн агуулга, дадлага, оюутан солилцоо	15
2	Анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн, ном сурах бичиг	3
3	Sisi систем	1
	Нийт	19

Хичээлийн хөтөлбөрийн сул талын доор хичээлийн хөтөлбөрийг хөгжүүлэх, Sisi системийн асуудал, багшийн ур чадвар, туршлагыг нэмэгдүүлэх, ажилчдын харилцааг сайжруулах асуудлыг тус тус дурдсан байв.

ОУХНУС-ийн хичээлийн хөтөлбөрийг сайжруулах хүчин зүйлийн нэгдүгээрт, хичээлийн агуулга, гадаад хэл дээрх хичээлийг нэмэгдүүлэх, дадлага хийх

хугацааг нэмэгдүүлэх, оюутан солилцооны хөтөлбөрийг хөгжүүлэх, нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзсэн байна.

ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

Хууль зүйн сургууль (ХЗС)-ийн 111 төгсөгч судалгаанд оролцсоноос нийт 90 орчим төгсөгч хөтөлбөрийн давуу болон сул талыг үнэлж, санал бодлоо илэрхийлсэн байна. Багцлан үзэхэд хичээлийн хөтөлбөрийн давуу талыг нийт 32 төгсөгч үнэлэхдээ, хичээлийн хөтөлбөр сайн, багшийн ур чадвар туршлага харьцангуй сайн, анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн хангалттай гэж үзжээ.

СУЛ ТАЛ		
№	Агуулга	Саналын тоо
1	Хичээлийн хөтөлбөрийг хөгжүүлэх шаардлагатай	13
2	Анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн	6
3	Багшийн ур чадвар, туршлага нэмэгдүүлэх, ажилчдын харилцааг сайжруулах	4
	Нийт	23
ДАВУУ ТАЛ		
1	Хичээлийн хөтөлбөр сайн	18
2	Багшийн ур чадвар, туршлага сайн	12
3	Анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн хангалттай	2
	Нийт	32
САЙЖРУУЛАХ ХҮЧИН ЗҮЙЛС		
1	Хичээлийн хөтөлбөр	18
2	Анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн, ном сурах бичиг	12
3	Багш, ажилчдын харилцаа, ур чадвар, туршлага	3
4	Sisi систем	1
	Нийт	34

ХЗС-ийн хичээлийн хөтөлбөрийг сайжруулах хэрэгтэй гэж 18 төгсөгч үзсэн бол, 12 төгсөгч анги танхимын тоог нэмэгдүүлэх, ном гарын авлага, номын санг тохижуулах шаардлагатай гэж үзсэн байна. Түүнчлэн багш ажилчдын харилцаа, ур чадвар, туршлагыг сайжруулах, Sisi системийг оюутан хэрэглэхэд хүндрэл, бэрхшээлгүй болгох нь чухал болохыг тэмдэглэсэн байна.

ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААН, ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛЬ

Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль (ХШУИС)-ийн 131 төгсөгч судалгаанд оролцсоноос 50 орчим төгсөгч хичээлийн хөтөлбөрийн талаар санал бодлоо илэрхийлсэн юм. Хичээлийн хөтөлбөрийн сул талыг 22 төгсөгч дурдсан бол, давуу талыг 12 төгсөгч, сайжруулах хүчин зүйлсийн талаар 15 төгсөгч санал бодлоо илэрхийлжээ.

СУЛ ТАЛ		
№	Агуулга	Саналын тоо
1	Хичээлийн хөтөлбөрийг хөгжүүлэх шаардлагатай	19
2	Sisi систем хөгжүүлэх	2
3	Анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн	1
	Нийт	22
ДАВУУ ТАЛ		
1	Хичээлийн хөтөлбөр сайн	6
2	Багшийн ур чадвар, туршлага сайн	4
3	Тухайн мэргэжлийн нийгэм дэх хэрэгцээ, эрэлт их байгаа	1
4	Анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн хангалттай, орчин сайн	1
	Нийт	12
САЙЖРУУЛАХ ХҮЧИН ЗҮЙЛС		
1	Хичээлийн хөтөлбөр	14
2	Анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн, ном сурах бичиг, дотуур байр	2
3	Sisi систем	1
	Нийт	15

ХШУИС-ийг төлөөлж судалгаанд хамрагдсан 21 төгсөгчдийн олонх нь (19 төгсөгч) дадлага, лабораторийн цаг бага, агуулга төстэй хичээл давтагддаг, мэргэжлийн хичээл хангалтгүй орсон, хичээлийн агуулга дутагдалтай, шаардлагагүй хичээл их орсон зэрэг хичээлийн хөтөлбөртэй холбоотой сул талуудыг дурдсан байна.

ОРХОН САЛБАР СУРГУУЛЬ

Орхон салбар сургууль (ОСС)-ийн 34 төгсөгч судалгаанд оролцсон бөгөөд хичээлийн хөтөлбөрийн давуу болон сул талыг үнэлж, цаашид сайжруулахтай холбоотой 30 орчим санал өгсөн байна.

СУЛ ТАЛ		
№	Агуулга	Саналын тоо
1	Хичээлийн хөтөлбөрийг хөгжүүлэх шаардлагатай	9
2	Багшийн ур чадвар, туршлага нэмэгдүүлэх, ажилчдын харилцааг сайжруулах	4
3	Анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн	2
4	Тухайн мэргэжлийн нийгэм дэх хэрэгцээ, эрэлт бага, төлбөр өндөр	1
	Нийт	16
ДАВУУ ТАЛ		
1	Хичээлийн хөтөлбөр сайн	16
2	Багшийн ур чадвар, туршлага сайн	10
3	Анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн хангалттай, орчин сайн	2
	Нийт	28
САЙЖРУУЛАХ ХҮЧИН ЗҮЙЛС		
1	Анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн, ном сурах бичиг, дотуур байр	14
2	Багш, ажилчдын харилцаа, ур чадвар, туршлага	6
3	Хичээлийн хөтөлбөр	5
4	Sisi систем	1
	Нийт	26

ОСС-ийн сайжруулах хүчин зүйлийн нэгдүгээрт дотуур байр, анги танхимын тоог нэмэгдүүлэх, номын сан, сургуулийн орчинг тохижуулах, хичээлийн техник хэрэгсэл сайжруулах шаардлагатай гэж үзсэн байна. Судалгаа авах явцад тус сургуулийн төгсөгчид сургалтын хөтөлбөрт цаашид анхаарвал зохих зарим нэг онцгой саналуудыг дурдаж байсан юм. Үүнд: Хөдөө орон нутгийн багш нар хоцрогдол ихтэй, ур чадвар дутмаг. Миний хувьд төв МУИС-д оюутан солилцоогоор очиход багш нарын заах арга барил болоод ур чадвар нь огт өөр байсан. Нэг номноосоо байнга заадаг. Техник технологи хөгжсөн энэ цагт 1990-ээд оны ном бариад, байнга онол яриад байх утгагүй. Өөр шинэ ном зөндөө байдгийг ашиглах нь чухал болов уу. Сургалтын арга барил муу. Оюутан яаж заавал хурдан ойлгож удаан ойлгох вэ гэдэг талаасаа биш их л хичээл зааж, хичээлийн агуулга их байхыг чухалчлах явдал хааяагүй тохиолддог.

Орхон салбар сургуулийн давуу тал:

- Оюутан цөөн учир багш нар оюутнуудтайгаа тулж ажиллаж илүү их мэдлэг олж авах боломжтой. Хүссэн үедээ багш дээрээ очоод хичээлээ заалгана гэдэг маш том боломж.
- Эдийн засгийн хувьд хэмнэлттэй. Учир нь хөдөө орон нутаг болохоор унааны мөнгөнөөс авахуулаад өртөг багатай суралцаж чадна. Мөн төв МУИС-тай харьцуулахад төлбөр хамаагүй хямд байдаг.
- Аюулгүй байдал. Хотод сурч буй оюутнуудтай харьцуулахад хөдөө орон нутагт байгаа учир янз бүрийн гэмт хэрэг, аюул осолд өртөх нь харьцангуй бага.
- Чанартай боловсон хүчин бэлтгэж чаддаг. Оюутан бүрт тулж хичээлээ заадаг учир мэдлэг сайн эзэмшдэг.
- Англи хэлийг англи багш заадаг нь үнэхээр том давуу тал болдог
- Гадаад оюутан солилцоогоор явуулдаг байсан нь хэлээ сайжруулах боломж олгодог байсан.
- Оюутнуудыг практик болон хувь хүн тал руу нь хөгжүүлэхэд анхаардаг.
- Төгсөөд ажлын байранд зуучлах болон нутагтаа ажиллах боломж их байдаг.

Цаашид сайжруулах зүйлс

- Гадаад болон дотоод орчноо сайжруулах
- Гадаад харилцааг сайн хөгжүүлэх
- Оюутны дотуур байрны тохижилт тааруу
- Техник хангамжийг сайжруулах
- Анги танхимын тоог нэмэх, хичээлээ хийх ч юм уу ер нь аливаа тэмцээн уралдаанд бэлдэх гэхэд анги олддоггүй
- Багшийн ур чадвар, заах арга барилыг дээшлүүлэх, мэдээж бүх багш нарыг муу гэж хэлэхгүй. Гэхдээ зарим багш нар аль дээр үеийн юм л ярьдаг, хоцрогдсон
- Номын санг том болгох
- Багш болоод ажилчдын харилцааны соёлыг дээшлүүлэх
- Оюутнуудыг зөвхөн сургах гэхээсээ илүү хувь хүнд чиглэсэн үйлчилгээг дэмжих

ЗАВХАН САЛБАР СУРГУУЛЬ

Завхан сургууль (ЗС)-ийн 29 төгсөгч судалгаанд оролцсоноос 22 төгсөгч саналаа өгсөн байна. Завхан сургуулийн давуу талыг тодорхойлсон 12 оролцогчдын 7 нь сургалтын хөтөлбөр чанартай, 3 нь анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн хангалттай, 2 нь багшийн ур чадвар сайн гэсэн саналыг өгсөн байна.

СУЛ ТАЛ		
№	Агуулга	Саналын тоо
1	Хичээлийн хөтөлбөр хөгжүүлэх шаардлагатай	3
2	Sisi систем хөгжүүлэх	1
3	Багшийн ур чадвар, туршлагыг нэмэгдүүлэх, ажилчдын харилцааг сайжруулах	1
4	Анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн тааруу	1
	Нийт	6
ДАВУУ ТАЛ		
1	Хичээлийн хөтөлбөр сайн	7
2	Анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн хангалттай	3
3	Багшийн ур чадвар, туршлага сайн	2
	Нийт	12
САЙЖРУУЛАХ ХҮЧИН ЗҮЙЛС		
1	Хичээлийн хөтөлбөр	3
2	Анги танхим, номын сан, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн, ном сурах бичиг	1
	Нийт	4

Харин тус сургуулийн сул талыг хичээлийн хөтөлбөрийг хөгжүүлэх, Sisi систем болон багшийн ур чадвар, туршлага нэмэгдүүлэх, ажилчдын харилцааг сайжруулах зэрэгт өгсөн бөгөөд ялангуяа сайжруулах хүчин зүйлсийг авч үзэхэд орон нутгийн шинжтэй асуудлууд тухайлбал, төв салбартайгаа оюутан солилцоо болон багш солилцоо хийж байх, хоорондын харилцаагаа гүнзгийрүүлэх, төгсөгчдөө ажилд зуучлах, төвөөс техник технологийн хувьд хоцрогдсон зэрэг олон зүйлсээр дутуу байгааг анхаарах, цаашид сургалтын систем, байршил болон анги танхимын хүрэлцээ, цайны газар гэх мэт сайжруулах, дадлага хийж буй байгууллагуудтай хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, сиси системээр хичээл сонголт хийхэд мэдэхгүй, чадахгүй зүйл тулгардаг, номын хүрэлцээ хангалтгүй зэргийг дурдсан байна.

4.2. МУИС-ийн сургалтын хөтөлбөрийн давуу ба сул тал, анхаарах зүйлс

Төв болон салбар сургуулийг төгсөгчид сургалтын хөтөлбөрийн талаар харилцан адилгүй байр суурь илэрхийлж байсныг нэгтгэн дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Ерөнхийдөө, МУИС-ийн сургалтын хөтөлбөрийн сул талаас илүүтэй давуу талыг төгсөгчид олонтаа дурдсан байна. Гэхдээ сургалтын хөтөлбөрт шууд хамаатай сул талуудыг төгсөгчид харилцан адилгүй илэрхийлсэн байгааг харах хэрэгтэй. Тухайлбал, Бизнесийн сургуулийг төгсөгчид багш, ажиллагсадтай холбоотой саналууд, багшийн ур чадвар, туршлагыг нэмэгдүүлэх, ажилчдын харилцааг сайжруулах талаар дурдсан бол ШУС, ХЗС, ОУХНУС, ХШУИС-ийг төгсөгчид хичээлийн хөтөлбөрийг хөгжүүлэх, Sisi системийг хөгжүүлэх шаардлагатай байгаа талаар зонхилон хариулт өгсөн байна.

Байршлаас хамаарч төв болон орон нутгийн салбар сургуулийн төгсөгчдийн хувьд ялгаатай байр суурь, үнэлгээ харагдаж байна. Орон нутаг дахь салбар сургуулийг төгсөгчдийн хувьд төв сургуулиудын орчин нөхцөлтэй харьцуулж, ихэнхдээ үнэлгээ дүгнэлт өгсөн байгааг хүснэгтэд дурдсан мэдээллээс ажиглаж болох юм.

Хүснэгт 4.1 Орон нутаг дахь салбар сургуулийг төгсөгчдийн үнэлгээ

Сургалтын хөтөлбөрийн давуу тал	Сургалтын хөтөлбөрийн сул тал
– Оюутан цөөн учир багш нар оюутнуудтайгаа тулж ажиллаж илүү их мэдлэг олж авах боломжтой. – Эдийн засгийн хувьд хэмнэлттэй. Учир нь хөдөө орон нутаг болохоор унааны мөнгөнөөс авахуулаад өртөг багатай суралцаж чадна. Мөн төв МУИС-тай харьцуулахад төлбөр хамаагүй хямд байдаг. – Аюулгүй байдал. Хотод сурч буй оюутнуудтай харьцуулахад хөдөө орон нутагт байгаа учир янз бүрийн гэмт хэрэг, аюул осолд өртөх нь харьцангуй бага. – Чанартай боловсон хүчин бэлтгэж чаддаг. – Оюутан бүрд тулж хичээлээ заадаг учир мэдлэг сайн эзэмшдэг.	– Багш нар хоцрогдол ихтэй, ур чадвар дутмаг. Миний хувьд төв МУИС-д оюутан солилцоогоор очиход багш нарын заах арга барил болоод ур чадвар нь огт өөр байсан. – Сургалтын арга барил муу. Оюутан яаж заавал хурдан ойлгож удаан ойлгох вэ гэдэг талаасаа биш хичээлийн агуулга их байхыг чухалчилдаг санагддаг. – Орон нутагт байдаг учраас хотын МУИС-д зарлагддаг тэтгэлэгт хөтөлбөрүүд болон оюутан солилцоо зарлагдах нь ховор байдаг.

– Англи хэлийг англи багш заадаг нь үнэхээр том давуу тал. Гадаад оюутан солилцоогоор явуулдаг байсан нь хэлээ сайжруулах боломж олгодог байсан. – Оюутнуудыг практик болон хувь хүн тал руу нь хөгжүүлэхэд анхаардаг. – Чөлөөт цаг их гардаг болохоор өөрийгөө хөгжүүлэх боломж их. Ямар ч түгжрэлгүй – Төгсөөд ажлын байранд зуучлах болон нутагтаа ажиллах боломж их байдаг.	– Хөгжих боломж харьцангуй бага. Учир нь цөөн оюутан ямар ч өрсөлдөөн байхгүй, нэг л хэвийн байдаг. Мөн оюутан цөөн болохоор хэтэрхий 10 жилийн сургууль шиг байдаг байсан. Оюутан ч багш нар ч бүгд л бие биенийгээ танина. Тиймээс хичээл зүтгэл нээх гаргахгүй. – -Цаг ашиглалт тааруу. Хичээл хооронд завсартай цагууд нэлээд гардаг. Тэр цагууд ихэвчлэн хийцгүй өнгөрдөг. Цөөхөн оюутантай байж зохицуулах боломж байхгүй л юм байх даа. – -Орчны хувьд олон сул тал бий. Жишээлбэл, Сургууль дээр суугаад хичээл хийх гэхэд ус буцалгагч ч байхгүй. Модон сандал нь удаан суухад хүндрэлтэй, номын сангийн үйл ажиллагаа болоод номын хүрэлцээ нь хомс.
--	--

Төгсөгчдийн дурдсан сул ба давуу талд тулгуурлан сургалтын хөтөлбөрийг хэрхэн сайжруулах талаар санал бодлыг нэгтгэн авч үзлээ. Төгсөгчдийн хувьд сургалтын хөтөлбөрийг сайжруулна гэдэг бол зөвхөн хичээл, сургалтын хөтөлбөртэй холбоотой зүйл биш, түүнээс өргөн хүрээтэй гадаад болон дотоод орчноос, сургалтын тогтолцооноос, суралцах орчин нөхцөлөөс, суралцагч оюутан болон сургагч багш нараас хамаатай зүйл гэж үзэж байна. Төгсөгчдийн хувьд сургалтын хөтөлбөрийг сайжруулахтай холбоотой дараах зүйлсийг дурдсан юм. Үүнд:

- Гадаад болон дотоод орчингоо сайжруулах/сандал, агааржуулагч, гадаад үзэмж гэх мэт/
- Сургалтын систем, тогтолцоог сайжруулах/аль болох оюутнуудыг бие даах тал руу нь чиглүүлэх ч гэдэг юм уу, ямар ч байсан байнга багш ярьдаг биш байлгах/
- Гадаад харилцааг сайн хөгжүүлэх/Гадаад руу нэг сар байсан ч хэд хоног байсан ч хамаагүй оюутан солилцооны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь нэн чухал/
- Оюутны дотуур байрны нөхцөлийг бүх талаар сайжруулахад анхаарах хэрэгтэй/ Гадаад оюутны дотуур байрны нөхцөл тааруу харагддаг. Хөдөө орон нутагт сургууль дотроо байдаг, тохижилт тааруу/

- Техник хангамжийг сайжруулах/Нөүтбүүк болон электрон самбар гэх мэт техник хэрэгслийн хүртээмжийг сайжруулах хэрэгтэй/
- Анги танхимын тоог нэмэх/ Өдөр суугаад хичээлээ хийх ч юм уу ер нь аливаа тэмцээн уралдаанд бэлдэх гэхэд анги олддоггүй. Хичээллэхэд хүртэл багтдаггүй тохиолдол байнга гарч байсан/
- Багшийн ур чадвар, заах арга барилыг дээшлүүлэх/ Мэдээж бүх багш нарыг муу гэж хэлэхгүй ч, зарим багш нар аль дээр үеийн юм яриад л зогсож байдаг/
- Багш болоод ажилчдын харилцааны соёлыг дээшлүүлэх/Орон нутагт номын санг том болгох, харин төв сургуулийн хувьд гоё номын сантай болсон ч, ажиллагсдын харилцааны соёлыг дээшлүүлэх шаардлагатай/
- Анх суралцах гэж буй оюутнуудыг мэргэжлээ сонгоход нь туслах хэрэгтэй. Зорилгоо тодорхойлоход нь туслах. Анх 1 курсэд орж ирэхэд нь мэргэжил сурталчлах өдөрлөг, ер нь тухайн сургуулийн ангиудын талаар мэдээлэл өгөх хэрэгтэй. Би 1 курсдээ юу юугаа ч мэдэхгүй явж байгаад орж байсан. Харин одоо бодоход зөв ангидаа орсон юм шиг байна./

Оюутнуудыг зөвхөн сургах гэхээсээ илүү хувь хүнд чиглэсэн үйлчилгээг дэмжих хэрэгтэй/ Хувь хүний хөгжлийн үйл ажиллагаа, ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах хэрэгтэй. Илтгэх урлаг, мэтгэлцээн, дадлага гэх мэт/

МУИС-ийн хувьд одоо хүрсэн ололт амжилтаа бататгахын зэрэгцээ цаашид сургалтын хөтөлбөрийг сайжруулж, хөгжүүлэхэд нэн шаардлагатай объектив ба субъектив хүчин зүйлс, оролцогч талуудын саналыг тусгах шаардлагатай ба ингэснээр хичээл, сургалтын үйл ажиллагааны чанарыг дээшлүүлж, суралцагчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх нөхцөлийг хангах болно.

4.3. Төгсөгчдийн холбоо ба мэдээллийн санг үүсгэх талаар оролцогчдын санал бодол

Судалгааны хүрээнд төгсөгчдөөс МУИС-ийг төгсөгчдийн холбооны талаар мэдээллийн сан үүсгэх талаар чухам ямар санал бодолтой байдгийг мэдэж авах зорилгоор хариулт авсан. Аливаа сургуулийн төгсөгчдийн холбоо институтжсэн, “хүчтэй” байх нь тухайн сургуулийн нэр хүнд, залгамж холбоог илэрхийлэх ба нөгөө талаар төгсөгчдийн холбоо нь ажил олгогчдоос ихэвчлэн бүрддэг тул төгсөгчдийг хөдөлмөрийн зах зээл дээр ажиллахад эерэгээр нөлөөлдөг томоохон хүчин зүйл юм.

МУИС-ийг төгсөгчдийн 90 гаруй хувь нь Төгсөгчдийн холбоог тогтвортой ажиллахыг дэмжинэ гэсэн хариулт өгсөн байна. Харин судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 7.7 хувь нь хариулт өгөөгүй болно.

Хүснэгт 4.2 Төгсөгчдийн холбоог тогтвортой ажиллахыг дэмжиж байна уу?

	Тоо	Хувь	Бодит хувь	Хуримтлагдсан хувь
Дэмжиж байна	933	90.5	98.0	98.0
Дэмжихгүй байна	19	1.8	2.0	100.0
Нийт	952	92.3	100.0	
Хариулаагүй	79	7.7		
Нэгдсэн дүн	1031	100.0		

Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг жигдрүүлэхтэй холбоотойгоор мэдээллийн сан байгуулах талаар мөн тодруулсан. Судалгаанд оролцогчдын 60 гаруй хувь нь дэмжиж байна, 1.8 хувь нь дэмжихгүй байна гэсэн хариулт өгсөн байна. Төгсөгчдийн 37.5 хувь нь тодорхой хариулт өгөөгүй байгаагаас үзэхэд мэдээллийн сан үүсгэх талаар мэдээлэл тааруу байгаа бололтой.

Хүснэгт 4.3 Мэдээллийн сан үүсгэхийг дэмжиж байна уу?

	Тоо	Хувь	Бодит хувь	Хуримтлагдсан хувь
Дэмжиж байна	625	60.6	97.0	97.0
Дэмжихгүй байна	19	1.8	3.0	100.0
Нийт	644	62.5	100.0	
Хариулаагүй	387	37.5		
Нэгдсэн дүн	1031	100.0		

МУИС-аас цаашид төгсөгчдийн холбоог бэхжүүлэх бодитой, шат дараалсан арга хэмжээг нэн даруй хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд зөвхөн тэнхимийн төгсөгчдийг “ой” тэмдэглэх үед “санаж” хандив цуглуулдаг хэмээн харах бус, байнга холбоотой байх, ажил мэргэжлийн мэдээлэл өгөх, дахин сургах, хамтран ажиллах зэрэг үйл ажиллагааг эрчимжүүлбэл зохино.

4.4. Их сургуулиас авсан үйлчилгээний талаарх үнэлгээ

МУИС-аас 2018-2019 онд төгсөгчдөд үзүүлсэн үйлчилгээг үндсэн есөн чиглэлээр үнэлгээний Лайкертийн үнэлгээний таван түвшинт хэмжигдэхүүнээр хэмжсэн. Тухайн үнэлгээний хэмжилтийн найдвартай байдлыг Кронбах Альфа ашиглан хэмжихэд $\alpha < 0.70$ - оос дээш байгаа нь хэмжилтийн түвшин үндэслэл сайтай болсныг харуулж байна.

Хүснэгт 4.4 Хэмжилтийн үндэслэлтэй байдал

Reliability Statistics

Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standardized Items	N of Items
.827	.827	9

Судалгааны үр дүнд тулгуурлан төгсөгчдийг суралцах явцад МУИС-аас үзүүлсэн үйлчилгээг 1-5 хүртэлх түвшин бүхий үнэлгээний шкалаар хэмжиж үзэхэд дараах онцлог харагдаж байна. МУИС-аас төгсөгчдөд үзүүлсэн үйлчилгээнд өгсөн үнэлгээний дундаж үзүүлэлтийг тооцож үзэхэд Цахим үйлчилгээ-3.62, Оюутны тэтгэлэг, санхүүгийн дэмжлэгийн үйлчилгээ-3.46, Оюутны байрны үйлчилгээ-3.45 харьцангуй өндөр үнэлгээтэй гарсан байна.

Хүснэгт 4.5 МУИС-аас төгсөгчдөд үзүүлсэн үйлчилгээ

	N	Доод утга	Дээд утга	Дундаж	Хазайлт
Цахим үйлчилгээ	898	1	5	3.62	1.001
Оюутны тэтгэлэг, санхүүгийн дэмжлэгийн үйлчилгээ	882	1	5	3.46	0.955
Оюутны байрны үйлчилгээ	833	1	5	3.45	0.987
Гадаад оюутан, оюутан солилцоо	871	1	5	3.41	0.998
Нийгмийн үйлчилгээ, оюутны байгууллагад үзүүлэх үйлчилгээ	882	1	5	3.36	1.011
Боловсролын зээлийн үйлчилгээ	833	1	5	3.35	1.039
Хөдөлмөр эрхлэлт, төгсөгчдийг дэмжих үйлчилгээ	887	1	5	3.15	1.039
Академик үйлчилгээ, хууль эрх зүйн зөвлөх үйлчилгээ	850	1	5	3.10	1.066
Эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад үзүүлэх үйлчилгээ	860	1	5	2.95	1.055

Дундаж үнэлгээ авсан дараагийн гурван үйлчилгээ бол Гадаад оюутан, оюутан солилцох үйлчилгээ-3.41, Нийгмийн үйлчилгээ, оюутны байгууллагад үзүүлэх үйлчилгээ-3.36, Боловсролын зээлийн үйлчилгээ-3.35 зэрэг болно.

Эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад үзүүлэх үйлчилгээг 2.95 буюу дунджаас доогуур үнэлсэн байгаа нь тухайн үйлчилгээг анхаарах шаардлагатай болохыг харуулж байна. МУИС-ийн Оюутан төгсөгчийн хэлтсээс санаачлан Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан дунд хугацааны стратеги, төлөвлөгөө боловсруулан хэдийнээ ажиллаж эхлээд байгаа билээ.

Түүнчлэн Академик үйлчилгээ, хууль эрх зүйн зөвлөх үйлчилгээ-3.10, Хөдөлмөр эрхлэлт, төгсөгчдийг дэмжих үйлчилгээнд 3.15 гэсэн үнэлгээ өгсөн байна.

БҮЛЭГ ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

МУИС-ийг 2018-2019 оны төгсөгчдийн суурь мэдээлэлд тулгуурлан төгсөгчидтэй утсаар холбогдож хөдөлмөр эрхлэлтийн байдал, эрхэлж буй ажлын төрөл хэлбэр, ажилд ороход нөлөөлсөн хүчин зүйлс, ажил эрхлэхгүй байгаа үндсэн шалтгааныг тодорхойлж, сургалтын хөтөлбөрийн давуу ба сул талыг үнэлүүлэхийн зэрэгцээ, их сургуулиас оюутанд үзүүлж буй үйлчилгээний чанарын талаарх төгсөгчдийн санал бодлыг энэхүү судалгааны хүрээнд тус тус тодорхойлсон.

МУИС-ийн нийт 7 бүрэлдэхүүн сургуульд суралцаж, 22.5 хувь нь өвөл, 77.5 хувь нь хаврын улиралд тус тус төгссөн бөгөөд энэхүү судалгаанд 2018-2019 оны хичээлийн жилд төгсөгчдийн 40-өөс багагүй хувь буюу 1031 төгсөгчдийг хамруулж, тэдгээрийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, хүлээлт, ажил хөдөлмөр эрхлээгүй шалтгаан зэргийг тодорхойлсон юм. Хүйсийн хувьд авч үзэхэд судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 67 хувь нь эмэгтэй, 33 хувь нь эрэгтэй оюутнууд байлаа.

Судалгааны үр дүнгээс үзэхэд нийт төгсөгчдийн **75.7 хувь нь ажил эрхэлдэг, 24.3 хувь нь ямар нэг ажил эрхлээгүй** гэсэн хариултыг өгсөн. 2015-2017 оны төгсөгчдийн түүвэр судалгаанаас үзэхэд 2015 онд төгсөгчдийн 72.8 хувь, 2016 онд төгсөгчдийн 73.4 хувь, 2017 онд төгсөгчдийн 73.0 хувь нь хөдөлмөр эрхэлж байсан дүн мэдээтэй харьцуулахад төгсөгчдийн ажил эрхлэлт өмнөх онуудаас харьцангуй өссөн байна. Хэдийгээр 2018-2019 оны төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин өссөн байгаа боловч төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт зөвхөн сургуулиас олгож буй мэдлэг, ур чадвараас гадна хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал, тухайн жилийн мэргэжлийн эрэлт, нийлүүлэлтээс тодорхой хэмжээгээр хамаардаг тул одоогийн хүрсэн үр дүн, амжилтыг цаашид хадгалах, улмаар тогтвортой өсөлтийг хангахад анхаарах нь зүй ёсны хэрэг болно.

Түүнчлэн 2018-2019 онд МУИС-ийг төгсөгчдийн хувьд 63.9 хувь нь эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж байгаа бөгөөд улсын дундаж үзүүлэлтээс дунджаас 5.7 хувиар доогуур байна. Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн хувьд хувиараа аж ахуй эрхэлж буй цөөнгүй хүмүүс байгаа нь дээрх үзүүлэлтэд тодорхой хэмжээгээр нөлөөлжээ.

Судалгаанд хамрагдсан МУИС-ийг төгсөгчдийн сарын дундаж мөнгөн орлого 1065.1 мянган төгрөг байгаа бөгөөд ажил эрхэлдэг төгсөгчдийн сарын дундаж мөнгөн орлого 1072.7 мянган төгрөг байхад ажил эрхэлдэггүй буюу түр ажил эрхэлдэг төгсөгчдийн хувьд 681.6 мянган төгрөгийн орлоготой, 1.6 дахин бага байна. Төгсөгчдийн сарын дундаж орлогыг хүйсийн хувьд харьцуулж үзэхэд эрэгтэй, эмэгтэй төгсөгчдийн хувьд онцлог ялгаатай байна. Тухайлбал, эмэгтэйчүүдийн хувьд дунджаар 968.5 мянган төгрөгийг дундаж орлогыг сард олдог бол эрэгтэйчүүд сард дунджаар 1255.4 мянган төгрөгийн орлого олдог буюу 286.9 мянган төгрөгөөр илүү орлоготой байв.

МУИС-ийн 2018-2019 оны хичээлийн жилд төгсөгчдөөс 20.9 хувь нь суралцах үедээ болон төгссөн даруйдаа ажил, хөдөлмөр эрхэлсэн байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд төгсөгчдийн 17.0% нь 4-7 сарын хугацаанд, 9.6% нь 8-12 сарын хугацааны дараа ажил хөдөлмөр эрхэлсэн бол, нийт төгсөгчдийн 6.9% нь нэг жил буюу түүнээс дээш хугацаанд хүлээж байж ажил хөдөлмөр эрхэлсэн байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд ажил эрхлэлт хамгийн өндөртэй гурван сургуульд ОУХНУС-88.9%, Бизнесийн сургууль-86.2%, Хууль зүйн сургууль-85.6% багтаж байна. Эдгээр сургуулийг төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь улсын дунджаас(75.2%) 10.4-13.7 хувиар өндөр байгаа юм. ХШУИС болон Завхан, Эрдэнэт сургуулиудын төгсөгчдийн 72-76 хувь нь ажил эрхэлж байгаа нь дундаж үзүүлэлт болно. Харин ШУС-ийг төгсөгчдийн хувьд ажил эрхлэлт 67.3 хувьтай байгаа нь хамгийн бага үзүүлэлт бөгөөд улсын дунджаас 7.9 хувиар доогуур байгааг анхаарч сургалтын хөтөлбөр болон төгсөгчдийн ажил мэргэжлийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд дүн шинжилгээ хийх шаардлагатай харагдаж байна.

Төгсөгчдийн оролцоотой ажилд ороход нөлөөлсөн хүчин зүйлсийг нэрлүүлэхэд хувийн зан чанар-23.5%, төгссөн сургууль-22.7%, Ерөнхий ур чадвар-16.8% тус тус ихээхэн нөлөөлдөг эхний гурван хүчин зүйл болохыг онцолжээ. Эдгээр хүчин зүйлсийг хүйсийн хувьд харьцуулан авч үзэхэд, эрэгтэй төгсөгчдийн хувьд **1)хувийн зан чанар-45.5%, 2)төгссөн сургууль-39.1%, 3)ерөнхий ур чадвар-37.5%**, ихээхэн нөлөөлдөг бол, эмэгтэй төгсөгчдийн хувьд **1)төгссөн сургууль-43.1%, 2)хувийн зан чанар-42.0%, 3)ерөнхий ур чадвар-27.2%** тус тус нөлөөлдөг ажээ. Өнөөдөр боловсролын зах зээлд чанартай суралцсан төгсөгчид хөдөлмөрийн зах зээлд ерөнхий ур чадвараар “маруухан” байгааг шат шатандаа хүлээн зөвшөөрч байна. Цаашид төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, ажил олгогчдын зүгээс төгсөгчдийн онолын мэдлэг төдийгүй ерөнхий ур чадварт тавих шаардлагыг сургалтын хөтөлбөрт тусган ажиллах шаардлагатай.

МУИС-ийг төгсөгчдийн хувьд ажил эрхлэхгүй байгаа үндсэн шалтгаанд ар гэрийн шалтгаан илүү өндөр хувь /22.1%/ эзэлж байна. Тухайн ажил эрхлэхгүй байгаа шалтгааныг дурдсан ялангуяа эмэгтэй төгсөгчдийн хувьд хүүхэд төрүүлсэн гэсэн хариулт зонхилж байгаагийн дээр хувиараа хөдөлмөр эрхэлдэг, гадаадад сурч байгаа(Австрали, Япон, Канад, Тайван гм) зэрэг хариултууд түгээмэл байв. Түүнчлэн судалгаанд хамрагдсан төгсөгчдийн удаах хэсэг нь үргэлжлүүлэн суралцаж байгаагаа илэрхийлсэн болно. Тухайн хариултыг судалгаанд оролцогчдын 21.8 хувь нь өгсөн юм. Мөн судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 14 хувь нь гадаад руу гарч ажиллах буюу сурахаар явсан гэсэн хариулт өгсөн юм. Ажил эрхлэхгүй байгаа 10 төгсөгч тутмын нэг нь мэргэжлээрээ ажил хайсан боловч олдохгүй байгаа гэсэн хариулт өгснийг анхаарах шаардлагатай.

Ерөнхийдөө, МУИС-ийн сургалтын хөтөлбөрийн сул талаас илүүтэй давуу талыг төгсөгчид олонтаа дурдсан байна. Гэхдээ сургалтын хөтөлбөрт шууд хамаатай сул талуудыг төгсөгчид харилцан адилгүй илэрхийлсэн байгааг харах хэрэгтэй. Тухайлбал, Бизнесийн сургуулийг төгсөгчид багш, ажиллагсадтай холбоотой

саналууд, багшийн ур чадвар, туршлагыг нэмэгдүүлэх, ажилчдын харилцааг сайжруулах талаар дурдсан бол ШУС, ХЗС, ОУХНУС, ХШУИС-ийг төгсөгчид хичээлийн хөтөлбөрийг хөгжүүлэх, Sisi системийг хөгжүүлэх шаардлагатай байгаа талаар зонхилон хариулт өгсөн байна. Төгсөгчдийн хувьд сургалтын хөтөлбөрийг сайжруулна гэдэг бол зөвхөн хичээл, сургалтын хөтөлбөртэй холбоотой зүйл биш, түүнээс өргөн хүрээтэй гадаад болон дотоод орчноос, сургалтын тогтолцооноос, суралцах орчин нөхцөлөөс, суралцагч болон сургагч багш нараас хамаатай зүйл гэж үзэж байна.

МУИС-ийг төгсөгчдийн 90 гаруй хувь нь Төгсөгчдийн холбоог тогтвортой ажиллахыг дэмжсэн хариулт өгсөн бол төгсөгчдийн мэдээллийн сан байгуулахыг төгсөгчдийн 60 гаруй хувь нь дэмжсэн хариулт өгсөн байна. Аливаа сургуулийн төгсөгчдийн холбоо институтжсэн, “хүчтэй” байх нь тухайн сургуулийн нэр хүнд, залгамж холбоог илэрхийлэх ба нөгөө талаар төгсөгчдийн холбоо нь ажил олгогчдоос ихэвчлэн бүрддэг тул төгсөгчдийг хөдөлмөрийн зах зээл дээр ажиллахад эерэгээр нөлөөлдөг томоохон хүчин зүйл гэдгийг анхаарч төгсөгчдийн холбоог бэхжүүлэх бодитой, шат дараалсан арга хэмжээг сургуулиас хэрэгжүүлэх нь зүйтэй болов уу. Үүнд зөвхөн тэнхимийн төгсөгчдийг “ой” тэмдэглэх үед “санаж” хандив цуглуулдаг хэмээн харах бус, байнга холбоотой байх, ажил мэргэжлийн мэдээлэл өгөх, дахин сургах, хамтран ажиллах зэрэг үйл ажиллагааг эрчимжүүлбэл зохино.

МУИС-аас төгсөгчдөд үзүүлсэн үйлчилгээнд өгсөн үнэлгээний дундаж үзүүлэлтийг тооцож үзэхэд Цахим үйлчилгээ-3.62, Оюутны тэтгэлэг, санхүүгийн дэмжлэгийн үйлчилгээ-3.46, Оюутны байрны үйлчилгээ-3.45 харьцангуй өндөр үнэлгээтэй гарсан байна. Түүнчлэн Академик үйлчилгээ, хууль эрх зүйн зөвлөх үйлчилгээ-3.10, Хөдөлмөр эрхлэлт, төгсөгчдийг дэмжих үйлчилгээ 3.15 гэсэн үзүүлэлттэй гарчээ. Эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад үзүүлэх үйлчилгээг 2.95 буюу бусад үйлчилгээний дундаж үзүүлэлтээс доогуур үнэлсэн байгаа нь тухайн үйлчилгээг анхаарч, хөгжүүлэх шаардлагатай болохыг илтгэж байна. Энэ талаар МУИС-ийн Оюутан төгсөгчийн хэлтсээс санаачлан Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан дунд хугацааны стратеги, төлөвлөгөө боловсруулан хэдийнээ ажиллаж эхлээд байгаа билээ.

ХАВСРАЛТУУД

ХАВСРАЛТ 1. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Телефон ярилцлага хийхийн өмнө судлаач телефон утас ашиглан ярилцлага чөлөөтэй өрнүүлж болохуйц байр, өрөөг урьдчилан бэлтгэсэн байх ба цаас, бал, харандаа, сурвалжилга хийх асуулт, хариултын цэс зэргийг бэлдсэн байна.

Судалгааг эхлэхийн өмнө товч танилцуулга хийнэ. Тухайн судалгаа нь МУИС-ийн ОТХ-ийн ажил үүргийн дагуу хийгдэж байгаа бөгөөд “МУИС-ийг төгсөгч оюутны хөдөлмөр эрхлэлт” сэдэвтэй болохыг танилцуулна. Судлаач өөрийгөө мөн танилцуулна. Судлаач хэлэлцүүлгийн төлөвлөгөөний дагуу ярилцлагыг явуулах, тэмдэглэл хөтлөхөд сайтар бэлдэж, ярилцлагын бүхий л үе шатанд хариултыг нэг бүрчлэн тэмдэглэхэд анхаарна.

Танилцуулгын дараа, ярилцлага эхлүүлэхийн өмнө “жавар үргээх” зорилгоор асуулт асууж, хариулт авч болно. Энэ нь ярилцлагыг идэвхтэй өрнүүлэх уур амьсгалыг бүрдүүлэхэд чиглэнэ. Тухайлбал, ярилцлагын өмнө төгсөгч оюутнаас өөрсдийнхөө санал бодлыг нээлттэй илэрхийлэх, санал бодлыг нь хүндэтгэж сонсох, нууцыг чандлан хадгалах талаар танилцуулж болох юм. Ярилцлага 5 минут үргэлжлэх болно гэдгийг урьдчилан сануулна уу?. Энэ үед тэмдэглэл хөтлөгч Телефон ярилцлага хийгдсэн огноо, эхэлсэн хугацааг тэмдэглэнэ. Мөн хаана, хэзээ, ямар хугацаанд хийгдсэнийг тэмдэглэнэ. Үүний дараагаар хэлэлцүүлгийн үндсэн хэсэгт шилжинэ.

ТЕЛЕФОН СУРВАЛЖЛАГЫН ДУГААР

№.....

СУДЛААЧИЙН ДУГААР/Оператор

№

ЯРИЛЦЛАГА ХИЙГДСЭН ОГНОО:

ЯРИЛЦЛАГЫН ҮР ДҮН: 1. ХИЙГДСЭН 2. ХИЙГДЭЭГҮЙ

ЯРИЛЦЛАГА ЭХЭЛСЭН ДУУССАН

Ярилцлагад оролцогчийн нэр, төгссөн сургууль, мэргэжил, голч дүн, хүйс, утас, цахим хаяг зэргийг жагсаалтаас тэмдэглэнэ үү.

ҮНДСЭН АСУУЛТУУД

1. Та ажил эрхэлж байгаа юу? 1. Тийм 2. Үгүй
2. Хэрэв ажил эрхэлж байгаа бол мэргэжлийн ажлаа хийж байгаа юу? 1. Тийм 2. Үгүй
3. Эрхэлж буй ажил
 1. Төрийн байгууллагад
 2. Төсвийн байгууллагад
 3. Хувийн хэвшлийн байгууллагад
 4. Хувиараа аж ахуй эрхэлдэг
 5. Төрийн бус байгууллагад
 6. Олон улсын байгууллагад
 7. Гадаадад ажиллаж, амьдардаг
 8. Өөр.....
- 4.1. Хаана ажиллаж байгаа вэ?
 1. Нийслэлд
 2. Аймагт
 3. Суманд
 4. Бусад.....
- 4.2. Ажил олгогчийн утас, хаягийг бичих /...../
5. Хэрэв ажил эрхлэхгүй байгаа бол үүний шалтгаан юу вэ?/3 хүртэл хариулт/
 1. Мэргэжлээрээ ажил хайсан боловч олдохгүй
 2. Ажлын байрны шаардлага хэт өндөр
 3. Ажлын ачаалал их
 4. Цалин бага
 5. Мэргэжилдээ сонирхолгүй
 6. Мэргэжлийн мэдлэг, ур чадвар дутмаг
 7. Ажил хайгаагүй
 8. Үргэлжлүүлэн суралцаж байгаа
 9. Гадаад орон руу явсан
 10. Ар гэрийн шалтгаанаар
 11. Эрүүл мэндийн шалтгаанаар
 12. Ажиллах шаардлагагүй
 13. Бусад.....
6. Сургууль төгсөөд ажилд орсон хугацаа /сараар бичих/ [.....]
7. Таны сарын дундаж цалин, мөнгөн орлого/төгрөгөөр/ [.....]
8. Ажилд ороход нөлөөлсөн хүчин зүйлс юу вэ?
 1. Сурлагын дүн
 2. Мэргэжлийн онцлог
 3. Төгссөн сургууль

4. Гадаад хэлний мэдлэг
5. Хувийн зан чанар
6. Ерөнхий ур чадвар
7. Мэргэжлийн дур сонирхол, чиг баримжаа
8. Өөр.....

9. Тухайн хөтөлбөрөөр суралцаж буй үед гарсан сул болон давуу талууд юу байсан бэ? Сайжруулах хүчин зүйл юу вэ?

Сул тал	Давуу тал	Сайжруулах зүйлс

10. Төгсөгчдийн холбоог тогтвортой ажиллуулах, мэдээллийн сан бий болговол дэмжих үү?

	Дэмжинэ	Дэмжихгүй
Төгсөгчдийн холбоог тогтвортой ажиллуулах	1	0
Мэдээллийн сан бий болгох	1	0

11. Төгсөгчийн хувьд сургуулийн үйлчилгээ болон чанарыг сайжруулах зүйлийг нэмж санал оруулна уу?

		Маш сайн	Сайн	Дунд	Тааруу	Маш муу	Сайжруулах тусгай санал
1	Боловсролын зээлийн үйлчилгээ	5	4	3	2	1	
2	Гадаад оюутан, оюутан солилцоо	5	4	3	2	1	
3	Хөдөлмөр эрхлэлт, төгсөгчдийг дэмжих үйлчилгээ	5	4	3	2	1	
4	Академик үйлчилгээ, хууль эрх зүйн зөвлөх үйлчилгээ	5	4	3	2	1	
5	Цахим үйлчилгээ	5	4	3	2	1	
6	Оюутны тэтгэлэг, санхүүгийн дэмжлэг, үйлчилгээ	5	4	3	2	1	
7	Оюутны байрны үйлчилгээ	5	4	3	2	1	

8	Эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад үзүүлэх үйлчилгээ	5	4	3	2	1	
9	Нийгмийн үйлчилгээ, оюутны байгууллагад үзүүлэх үйлчилгээ	5	4	3	2	1	

12. Нэмэлт санал байгаа бол бичих

В. СУДАЛГААГ ДУУСГАХ

Судалгаа тавьсан зорилгодоо хүрсэн эсэх, судалгааны асуултад хариулсан байдлыг судлаач шалгаж үзнэ. Эргэлзээтэй, тодруулвал зохих асуултыг дахин асууж, лавлаж болно.

Ойлгоогүй, эсвэл нэмэлт санал байгаа эсэхийг дахин лавлаж асууна уу.

Судлаач ярилцлага хийх явцдаа ярилцлагын үр дүнг Excel программ дээр тэмдэглэл хийнэ. Зөрчилтэй, хариултыг тусгайлан цаасан дээр тэмдэглэж, дүгнэн, нэгдсэн ойлголттой болсны дараагаар программд мэдээллийг оруулна.

ТАНД АМЖИЛТ ХҮСЬЕ. СУДАЛГААНЫ БАГ

ХАВСРАЛТ 2. “МУИС-ИЙГ ТӨГСӨГЧ ОЮУТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ” СЭДЭВТ СУДАЛГААГ ХИЙХЭД АНХААРАХ ЗҮЙЛС

Энэхүү судалгааны ажлын удирдамж нь “МУИС-ийг төгсөгч оюутны хөдөлмөр эрхлэлт” сэдэвт судалгааг хэрхэн хийх тухай аргачилсан зөвлөмж болно. Тухайн удирдамжийг судлаач болон мэдээлэл цуглуулах нэгжид зориулан боловсруулсан бөгөөд судлаачийн зүгээс анхаарах ёс зүйн асуудлуудыг тусгасан.

СУДЛААЧИЙН ЗҮГЭЭС АНХААРВАЛ ЗОХИХ ЗҮЙЛС:

1. Хүний эрхийг дээдлэх зарчмыг судалгаанд баримтлах

Олон улсын гэрээ конвенцод тусгагдсан заалтууд болон бусад хууль тогтоомж, судалгааны ёс зүйн кодекст тусгасан хүний эрхийг дээдлэх зарчмыг судалгаа хийх явцдаа баримтлан ажиллах. Үүнд: нас, хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг, бэлгийн чиг баримжаа, гэр бүлийн байдал, нийгмийн байдлаар ялгаварлахгүй байх, хувь хүний ялгаатай байдлыг хүндэтгэх гм.

2. Респондентод хувийн үзэл бодлоо тулгахаас зайлсхийх

Оюутнуудтай ярилцах явцдаа хувь хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг дээдлэхийн зэрэгцээ судалгааны асуулттай холбоотой үнэн зөв мэдээлэл, тайлбар өгөхөд анхаарна.

3. Мэдээллийн нууцлалыг чанд хадгалах, хамгаалах

Хувь хүний нууцын тухай хуулийн 2-р бүлгийн 5-р зүйлийн 4-т дурдсан “Хувь хүний нууцыг хуулийн дагуу болон итгэмжлэлээр олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглоно.” хэмээх заалтын дагуу мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах үүргийг судлаач биечлэн хүлээнэ.

4. Шаардлагатай мэдээллийг баталгаажуулах, баримтжуулах

Хэрэв шаардлагатай бол судлаач тухайн мэдээллийг баталгаажуулах ба баримтжуулалтын аливаа төрлийг ашиглахдаа судалгаанд оролцогчоос(оюутан, ажилтан гм) зөвшөөрөл авсан байвал зохино. Мэдээллийг баталгаажуулах дараах төрлүүд байж болно.

- Компьютерт зориулалтын Excel программ дээр хариултыг бичиж тэмдэглэх
- Цаасан дээр тэмдэглэл хөтлөх

5. Судалгааны ёс зүйн зарчмыг мөрдөх

Судлаач тухайн судалгааг /Олон улсын ёс зүйн кодекс/ ёс зүйн дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэхэд анхаарна. Энэхүү судалгаа нь оюутны хөдөлмөр эрхлэлтийн санал бодол, хандлагыг тодорхойлж, үндэсний түвшинд ашиглагдах мэдээллийн эх сурвалж бий болгох тул, энэ талаар тайлбарлан таниулах хэрэгтэй.

Уншиж танилцсан судлаач: /

/